



Монгол Улсад хэрэгжүүлэх стратеги 2022-2027

2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Удирдах
зөвлөлийн хурлаар батлав.



European Bank
for Reconstruction and Development



Баримт бичгийн эхийн орчуулгыг ЕСБХБ-аас уншигчдад зөвхөн дөхөм болгох үүднээс гаргасан болно. ЕСБХБ орчуулгыг үнэн зөв байлгах тал дээр зохих ёсоор анхаарч ажилласан хэдий ч ЕСБХБ нь орчуулгын үнэн зөвийг баталгаажуулахгүй болно. Орчуулгад найдах эрсдлийг уншигч өөрөө хариуцна. Ямар ч тохиолдолд ЕСБХБ, түүний ажилчид болон агентууд орчуулгын аливаа алдаатай, орхигдуулсан, устгасан, дутсан болон/эсвэл агуулгын өөрчлөлтөөс үүдэн гарсан аливаа хохиролд уншигч эсвэл өөр хэн нэгний өмнө хариуцлага хүлээхгүй. Англи хэл болон орчуулсан хувилбарын хооронд ойлголтын зөрүү, зөрчил үүсвэл англи хэл дээрх хувилбарыг баримтална.

Агуулга, нэр томъёоны тайлбар



European Bank
for Reconstruction and Development

Агуулга		Үндсэн нэр томъёоны тайлбар		ОУВС ОУСБ	Олон улсын валютын сан Олон улсын санхүүгийн байгууллагууд
Хураангуй	3	АЗЗГ АҮХХААБ	Анхдагч зах зээлд гаргах Аж үйлдвэр, худалдаа, хөдөө аж ахуйн бизнес	ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
Монгол Улс ба ЕСБХБ-ны товч тойм	5	БЖХО	Бизнесийн жилийн хөрөнгө оруулалт	ОУЭХА ОУИТБС	Олон улсын эрчим хүчний агентлаг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
I. Өмнөх стратегийн хэрэгжилт (2017-2021)	6	БОН	Байгаль орчин, нийгмийн	СБ	Санхүүгийн байгууллага
<i>Шилжилтийн гол үр дүн</i>	7	БОНБ БОННУ	Байгаль орчин, нийгмийн бодлого Байгаль орчин, нийгмийн	СТБ	Санхүүгийн түнш байгууллага
<i>Хэрэгжилтэд тулгарч буй асуудал, гол сургамжууд</i>	8		нөлөөллийн үнэлгээ	СЭХ	Сэргээгдэх эрчим хүч
II. Эдийн засгийн нөхцөл байдал	9	БОНЗ БОНУТ	Байгаль орчин, нийгэм, засаглал Байгаль орчин, нийгмийн	ТА	Төв Ази
<i>Макро эдийн засгийн нөхцөл байдал, хэтийн төлөв</i>	9		удирдлагын тогтолцоо	ТМБС	Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт
<i>Шилжилтийн гол асуудлууд</i>	10	БЭХ	Бизнес дэх эмэгтэйчүүдийн хөтөлбөр	ТӨҮГ ТТ	Төрийн өмчит үйлдвэрийн газар Техникийн тусламж
III. Засгийн газрын тэргүүлэх чиглэл, оролцогч талуудын үүрэг оролцоо	12	ГШХҮ ДБ ДМТ ДНБ ДХҮ ДЭЗТБ	Гадаадын шууд хөрөнгө оруулалт Дэлхийн Банк Дотоодын мөнгөн тэмдэгт Дотоодын нийт бүтээгдэхүүн Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд Дэлхийн эдийн засгийн төлөв байдал	ТШН УБ УУХҮЯ ҮҮ ҮХТХЗ	Тооцоолсон шилжилтийн нөлөө Улаанбаатар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам Үйлдвэрлэл, үйлчилгээ Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт
IV. ЕСБХБ-ны улс орон дахь стратегийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох нь	13	ДЭЗФ ЕСБХБ	Дэлхийн эдийн засгийн форум Европын сэргээн босголт хөгжлийн банк	ҮХЯУ ХАЁТ ХДХ ХҮИ ХХ ХХХТ	Үйл ажиллагаа явуулж буй улс Хөгжлийн албан ёсны тусламж Худалдааг дэмжих хөтөлбөр Хэрэглээний үнийн индекс Хүлэмжийн хий
V. Үйл ажиллагааны бүтэц, үр дүн	14	ЕХ ЖБЗ ЖДҮ МСБ МХХТ	Европын Холбоо Жижиг бизнесийн зөвлөгөө Жижиг, дунд үйлдвэр Мөнгө санхүүгийн байгууллага Мэдээлэл, харилцаа холбооны технологи	ЦХХХЯ	Харилцаа холбоо, хэвлэл мэдээлэл, технологи
— Олон улсын түншүүдийн ЕСБХБ-ны үйл ажиллагааны чиглэлүүд дэх нэмэлт оролцоог дүрслэн харуулах нь	17	НХҮАТ	Ногоон хотын үйл ажиллагааны төлөвлөгөө	ЧЗ ШҮБН ШШЧҮ	Цахим хөгжил, харилцаа холбооны яам Чанаргүй зээл Шилжилтийн үеийн багцын нөлөө Шилжилтийн шинж чанаруудын үнэлгээ
— Хэрэгжилтийн эрсдэл, байгаль орчин, нийгмийн үр дагавар	18	НЭЗСХ	Ногоон эдийн засгийн санхүүжилтийн хөтөлбөр	ЭМАБ ЭЗХЯ	Эрүүл мэнд, аюулгүй байдал Эдийн засаг, хөгжлийн яам
— Донор байгууллагын хамтарсан санхүүжилтийн үнэлгээ	19	НЭЗШ НЭХХ ОТ	Ногоон эдийн засгийн шилжилт Нийт эрчим хүчний хангамж Оюу Толгой		
Хавсралт 1 – Улс төрийн нөхцөл байдлын үнэлгээ	20				

Монгол Улс сүүлчийн стратеги батлагдсанаас хойшхи хугацаанд тус Банкйг байгуулах тухай Хэлэлцээрийн 1 дүгээр зүйл заасан зарчмуудыг баримталж, хэрэгжүүлсээр ирсэн. 1992 оны Үндсэн хуульд 1990 оны ардчилсан хувьсгалын зарчмуудыг тусгаж, “Хүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлоох”-ыг эрхэм дээд зорилго болгон тунхагласан. 2019 оны 11 дүгээр сард эрх мэдлийн хуваарилалт, шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх зорилгоор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар эдгээр үндсэн суурь зарчмуудыг улам бэхжүүлсэн.

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Монгол Улс 2010-2019 онд жилд дунджаар 7.8 хувийн өсөлттэй, дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж буй эдийн засагтай орнуудын нэг байсан бөгөөд үүнд уул уурхайн салбар голлох нөлөөг үзүүлсэн. Олон улс орны нэгэн адил Ковид-19 цар тахлын үеэр эдийн засаг агшиж, экспортын хэмжээ ихээхэн буурсан ч үүнийг гол түүхий эдийн (нүүрс, зэс) үнийн таатай нөхцөл нөхсөн. Гэсэн хэдий ч Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдалд хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт, БНХАУ-ын хил хэсэгчлэн хаалттай байгаа нь ашигт малтмалын экспортод сөргөөр нөлөөлж, Украиний дайнтай холбогдуулан олон улсын хориг арга хэмжээнд орсy улмаас ОХУ-аас импортлох ихэнхи бараа, бүтээгдэхүүнээ өөр чиглэлд шилжүүлэх шаардлагатай байгаа тул эдийн засгийн тогтвортой байдал эрсдэлтэй хэвээр байна. Цар тахлын эсрэг эдийн засгийг сэргээхэд зориулж авсан өргөн хүрээтэй арга хэмжээ нь тус улсын санхүү, төсвийн байдлыг улам дордуулсан тул Засгийн газрын өрийн өндөр түвшин гол асуудал хэвээр байна.

Монгол Улсын сүүлчийн стратеги батлагдсанаас хойш саяхан батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого” болон “Алсын хараа – 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд эдийн засгаа төрөлжүүлэх, бүс нутгийн хөгжил, ногоон хөгжлийг дэмжих, бэрхшээлийг даван туулах чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ зэрэг үндсэн шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсээр ирсэн. Цар тахлын эсрэг Засгийн газраас өргөн мэдүүлсэн эдийн засгаа сэргээхэд чиглэсэн иж бүрэн багц хөтөлбөр нь эдийн засгийг тогтворжуулахад дэмжлэг үзүүлж, хөрөнгийн хөрвөх чадвараар хангаж, банкны салбарт үзүүлэх дарамтыг бууруулсан. Түүнчлэн, 2022 оны эхээр Оюутолгойн ордыг ашиглах асуудлаар Рио Тинто компанитай шийдэлд хүрч чадсан нь цаашид хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах учиртай юм.

Гэхдээ эдгээр арга хэмжээг үл харгалзан шилжилтийн үйл явцад учир дутагдалтай нилээд олон зүйл байсаар байна. Эдийн засаг нь ДНБ-ий 20 орчим хувийг бүрдүүлдэг олборлох үйлдвэрлэлд төвлөрсөн хэвээр, ашигт малтмалын экспортын бараг 90 хувь нь БНХАУ руу гарч байгаа нь дэлхийн түүхий эдийн үнийн хэлбэлзэл, эдийн засгийн өсөлт/уналтын мөчлөгт өртөж байна. Мөн төсвийн хязгаарлагдмал нөөц нь тээврийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын өндөр хэрэгцээг хангаж чадахгүй байгаа нь ложистик, худалдааны үр ашигт сөргөөр нөлөөлсөн. Түүнчлэн хуучирч, үр ашиггүй болсон эрчим хүчний систем нь нүүрс болон ОХУ-ын импортоос ихээхэн хамааралтай, орон даяар дижитал дэд бүтэц, харилцаа холбооны боломж хязгаарлагдмал, газар тариалангийн өргөн цар хүрээтэй, хөрөнгө мөнгө ихээхэн шаарддаг үйл ажиллагаанд тулгуурладаг эрчим хүч, мэдээлэл харилцаа холбооны технологи болон хөдөө аж ахуйн салбарт томоохон орон зай байсаар байна. Уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий байдал нэмэгдэж байгаа нь хот суурин газрууд, ялангуяа Улаанбаатар хот руу чиглэсэн хяналтгүй шилжилт хөдөлгөөнд хүргэж, хотын нөөцийг улам бүр шавхаж, орон даяар интеграцийн асуудлыг хурцатгаж байна.

Цаашид ч гэсэн уул уурхайн салбар нь Монгол Улсын эдийн засгийн гол хөдөлгөгч хүч хэвээр байх боловч тус Банк нь эдийн засгийн төрөлжилтийг үргэлжлүүлэн дэмжих замаар, тэр дундаа санхүүгийн салбарыг илүү хүчтэй, уян хатан болгох, үндэсний мөнгөн тэмдэгтийг илүү ихээр ашиглах хэрэглээг өргөжүүлэх замаар холбогдох давтамжийг даван туулахад тусалж чадна. Түүнчлэн бүс нутгийн интеграцийг нэмэгдүүлэх боломжтой дотоодын тээвэр, эрчим хүч, дижитал харилцаа холбоо зэрэг санхүүгийн болон геополитикийн хязгаарлалтыг үл

харгалзан харилцаа холбооны хөтөлбөрийг урагшлуулахын төлөө ажиллах болно. Эцэст нь, тус Банкны хариуцлагатай уул уурхайг дэмжих туслалцаа нь тус салбарын байгаль орчны тогтвортой байдлыг сайжруулахад тус дөхөм үзүүлэхээс гадна Монгол Улсын ногоон хөгжлийн тухай үзэл баримтлалд нийцсэн дэвшилтэт технологид шаардлагатай онц чухал түүхий эдийг үйлдвэрлэх замаар ногоон шилжилтийг дэмжихэд шууд хувь нэмэр оруулах болно. Монгол Улс ҮХЦ-ийн амбицтай зорилтуудыг хэрэгжүүлэхэд гарын үсэг зурсан бөгөөд Банк олон улсын түншүүд болон хувийн хэвшилтэй хамтран эдгээр ноцтой сорилтуудыг шийдвэрлэхэд тусалж чадна. Монгол Улс “Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт” (ҮХТХЗ)-д гарын үсэг зурсан бөгөөд тус Банк нь олон улсын түншүүд болон хувийн хэвшлийнхэнтэй хамтран эдгээр томоохон асуудлуудыг шийдвэрлэхэд тусалж чадна.

Үүнийг харгалзан тус Банк нь 2022-2027 онд Монгол Улсад дараах стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг хэрэгжүүлэхээр зорьж байна. Эдгээр нь:

- Илүү хүчирхэг, төрөлжсөн, тогтвортой хувийн хэвшлийг бий болгох замаар Монгол Улсын бэрхшээлийг даван туулах чадварыг нэмэгдүүлэх;
- Өсөлтийг дэмжих, оролцоог нэмэгдүүлэхийн тулд харилцаа холбоо, бүс нутгийн интеграцчлалыг бэхжүүлэх; болон
- Тогтвортой эрчим хүч, дэд бүтэц, уул уурхайг хөгжүүлэх замаар илүү ногоон, уур амьсгалд илүү тэсвэртэй эдийн засгийг дэмжих.

Монгол Улс ба ЕСБХБ-ны товч тойм





European Bank
for Reconstruction and Development

ЕСБХБ-ны хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа (2022 оны 8 дугаар сарын байдлаар)

Хөрөнгийн багц	€879m	Идэвхтэй төсөл	45
Хөрөнгийн хувь	5%	Үйл ажиллагааны хөрөнгө	€734m
Хувийн хэвшлийн хувь ¹	74.4%	Нийт хөрөнгө оруулалт	€2,222m



БЖХО ба Үйл ажиллагаа

Хөрөнгийн багцын бүтэц



Хөрөнгийн багцын динамик

Шилжилтийн зөрүү²



Монголын тоо, баримтууд

	Монгол Улс	Харьцуулсан улс
Хүн ам (сая) (2021)	3.4	Казахстан (19.1) БНКиргиз Улс (6.7) Узбекистан (35.2)
Нэг хүнд ногдох ДНБ (ТХХТ, ам.доллар) ³ (2021)	12,862.7	Казахстан (28,600) БНКиргиз Улс (5,287.8) Узбекистан (8,497.4)
ДЭЗФ, Дэлхийн өрсөлдөх чадварын индекс (2019) (141 эдийн засгаас)	102-т	Казахстан (55th) БНКиргиз Улс (96th) Узбекистан (NA)
Ажилгүйдэл (% ОУХБ-ын үнэлэлт) ⁴ (2021)	7.1	Казахстан (4.9) БНКиргиз Улс (9.1) Узбекистан (7.2)
Залуучуудын ажилгүйдэл (% ОУХБ-ын үнэлэлт) ⁴ (2021)	21	Казахстан (3.7) БНКиргиз Улс (19.3) Узбекистан (15.9)
Ажиллах хүчин дэх эмэгтэйчүүдийн оролцоо (% ОУХБ-ын үнэлэлт) ⁴ (2020)	51.5	Казахстан (63.6) БНКиргиз Улс (41.6) Узбекистан (44.8)
Эрчим хүчний зарцуулалт (НЭХХ/ДНБ) ⁵ (2018)	7.2	Казахстан (6.6) БНКиргиз Улс (5.7) Узбекистан (8.1)
Хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ/ДНБ (kgCO2/2015\$) ⁵ (2019)	1.6	Казахстан (1) БНКиргиз Улс (1.2) Узбекистан (1.1)


¹ Банкны нийт хөрөнгө оруулалт – багцын 5 жилийн эргэлтийн хугацаа. ² Харьц. ЕСБХБ-ны 2021-2022 оны шилжилтийн тайланг үү. ³ Дэлхийн банкны ДХҮ. ⁴ Олон улсын хөдөлмөрийн байгууллага (багцаалсан). ⁵ ОУЭХА-ийн Эрчим хүчний атлас.

1. Өмнөх стратегийн хэрэгжилт (2017-2021)




European Bank
for Reconstruction and Development

1.1. Шилжилтийн гол үр дүн



Тэргүүлэх зорилт 1: Олборлох бус салбарын өрсөлдөх чадварыг бэхжүүлж, санхүүгийн хүртээмжийг хөнгөвчлөх замаар Монголын бэрхшээлийг даван туулах чадварыг нэмэгдүүлэх.



* Шилжилтийн нөлөөллийн үзүүлэлтүүд нь төсөлд гарын үсэг зурах үед хүлээгдэж буй шилжилтийн үр дүнг үзүүлэх магадлалыг тусгадаг. Идэвхтэй (> 2 жил) багцад үндэслэн тооцоолсон

European Bank
for Reconstruction and Development

1.1. Шилжилтийн гол үр дүн

Тэргүүлэх зорилт 2: Тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, үнэ цэнийг нэмэгдүүлэхийн тулд сайн менежменттэй уул уурхайн салбарыг ашиглах нь




Шилжилтийн гол үр дүн

- Уул уурхайн салбарт дотоодын ложистикийн компаниуд, тоног төхөөрөмж нийлүүлэгчид болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд зөвлөгөө өгөх, шууд санхүүжилт хийх, ХААН Банктай хамтран “VCF” зээлийн шугам (13.8 сая евро) олгох замаар дэмжсэн.
- Уул уурхайн салбарт хүнд машин механизм нийлүүлэгч Монголын “Вагнер Ази тоног төхөөрөмж” компанид эргэлтийн хөрөнгийн хэрэглээг санхүүжүүлэх, дотоодын мөнгөн тэмдэгийн хэлбэлзэлд өртөх эрсдэлийг зохицуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ХААН Банктай хийсэн “RSF”-ийн хүрээнд дотоодын валютын анхны гүйлгээнд 8 сая еврогийн баталгаа гаргаж өгсөн.
- 4.3 сая еврогийн хөрвөх боломжтой зээлээр алт олборлогч Эрдэнэт Ресурс Девелопмент Корпорацаас алтны хоёр ордоос олборлолт явуулахын өмнөх судалгааг хэрэгжүүлэхэд санхүүжүүлсэн.
- УУХҮЯ, ОУСБ болон хувийн хэвшилтэй олон бодлогын санаачилга гаргасан, үүнд (i) уул уурхайн салбарын хууль эрх зүй, институцийн тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр харилцан ойлголцлын Санамж бичигт гарын үсэг зурах, (ii) уул уурхайн салбараас олсон орлогыг Засгийн газар зөв зохистой зарцуулдаг байх үүднээс Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг шинэчлэн найруулах, (iii) уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтад тулгарч буй саад бэрхшээл, сайжруулах хөшүүргийг тодорхойлох жишиг судалгааг эхлүүлсэн.
- Уул уурхайн салбарын ГШХО-ыг татах чадварыг нэмэгдүүлэхийн тулд Засгийн газар болон Оюу Толгой компанитай бодлогын яриа хэлэлцээг үргэлжлүүлж, тэр дундаа улс орны хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад чиглэсэн ТХА төслүүдийн хүрээг бүрдүүлэх харилцан ойлголцлын Санамж бичигт гарын үсэг зурсан.
- Уул уурхайн салбарын цаашдын ил тод байдлыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор Үндэсний геошинжлэх ухааны мэдээллийн санг хөгжүүлэх ТТ-ыг олгосон.

Тэргүүлэх зорилт 3: Үр ашгийг нэмэгдүүлэх, арилжааны хэлбэрт оруулах, “ногоон” шийдлээр дамжуулан дэд бүтцийн үйлчилгээний чанар, тогтвортой байдлыг сайжруулах нь

НЭЗШ



Шилжилтийн гол үр дүн

- СO2 ялгаруулалтыг жилд 200,000 тонноор бууруулах 55МВт-ын хүчин чадалтай Сайншандын салхин цахилгаан станцын бүтээн байгуулалтад 26 сая еврогийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд энэ нь Монгол Улсад хэрэгжиж эхэлсэн гурав дахь салхины эрчим хүчний төсөл юм.
- Эрчим хүчний нийлүүлэлтэд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх шугам сүлжээний хүчин чадлыг үнэлэх ТЭЗҮ-г боловсруулж, сэргээгдэх эрчим хүчний өрсөлдөх чадвартай тендэрийг боловсруулах ТТ өгсөн.
- Хатуу хог хаягдлын салбарын институцийн шинэчлэлийн замын зураглалыг боловсруулах ТТ-ны хамт Улаанбаатар хотод шинэ хогийн цэг, хог хаягдлыг дахин боловсруулах байгууламж барихад 8.5 сая еврогийн хөрөнгө оруулалт хийсэн.
- Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, СO2 ялгарлыг бууруулах зорилгоор Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн салбарыг сэргээн засварлах, шинэчлэх ажлыг (8.2 сая евро) санхүүжүүлсэн.
- Дэд бүтцийн хөгжилд зориулж 2019 онд НИТХ-аас НХҮАТ-г баталж, “Ногоон хотууд” санаачилгыг УБ хотод эхлүүлсэн.
- Үерээс хамгаалах орчин үеийн арга хэмжээг хэрэгжүүлэх, усан хангамжийн системийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Эрдэнэт хотын Уур амьсгалд дасан зохицох төсөлд (6.2 сая евро) гарын үсэг зурсан.
- Нийслэл хотыг Монгол Улсын гурав дахь том хоттой холбох, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, замын санхүүжилтийн арга барилыг сайжруулахад зориулж Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын төслийг өргөтгөхөд 112.7 сая еврогийн санхүүжилт олгосон.
- MonSEFF-ийн хүрээнд Монгол Улсын тогтвортой эрчим хүчний төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор ХААН банкинд эрчим хүчний үр ашигтай хоёр зээл (4.3 сая евро) олгоосон.

1. Өмнөх стратегийн хэрэгжилт (2017-2021)



European Bank
for Reconstruction and Development

1.2. Хэрэгжилтэд тулгарч буй асуудлууд, гол сургамжууд

Хэрэгжилтийн нөхцөл байдал

Сүүлчийн стратегийг хэрэгжүүлснээс хойш Монгол Улс 2019 онд Үндсэн хуульдаа томоохон нэмэлт, өөрчлөлт оруулж, “Алсын хараа 2050” болон Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд эдийн засгаа цаашид төрөлжүүлэх, бэрхшээл даван туулах чадавхийг бэхжүүлэх хэд хэдэн арга хэмжээг багтаасан гол шинэчлэлүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсээр ирсэн. Цар тахлын нөхцөл нөлөөллийг арилгахын тулд Засгийн газраас эдийн засгийг тогтворжуулах, нэн шаардлагатай хөрвөх хөрөнгөөр хангах, банкны салбарт үзүүлэх дарамтыг бууруулах зорилгоор иж бүрэн эдийн засгаа сэргээх багцыг баталсан. Мөн 2022 оны эхээр Оюутолгойн ордыг ашиглах асуудлаар Рио Тинтотой шийдэлд хүрсэн нь цаашид хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах учиртай юм. Гэхдээ эдгээр арга хэмжээг үл харгалзан шилжилтийн үйл явцад ихээхэн дутагдалтай зүйлс байсаар байна. Эдийн засаг нь олборлох үйлдвэрлэлд ихээхэн төвлөрсөн хэвээр байгаа бөгөөд ашигт малтмалын экспортын бараг 90 хувь нь БНХАУ руу чиглэж байгаа нь эдийн засгийн өсөлтийг дэлхийн түүхий эдийн үнийн хэлбэлзэл, эдийн засгийн өсөлт/уналтын мөчлөгийн хэлбэлзэлд хүргэж байна. Мөн төсвийн хязгаарлагдмал нөөц нь тээврийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын өндөр хэрэгцээг хангаж чадахгүй байгаа нь ложистик, худалдаанд үр ашигт сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн эрчим хүч, мэдээлэл харилцаа холбооны технологи, хөдөө аж ахуйн салбарт дутагдалтай зүйл ихээхэн байсаар байгаа бөгөөд үүнд нүүрс болон ОХУ-ын импортоос ихээхэн хамааралтай эрчим хүчний хуучирсан, үр ашиггүй тогтолцоо, дижитал харилцаа холбооны хязгаарлагдмал байдал, хөрөнгө нөөц ихээхэн шаардсан газар тариалангийн үйл ажиллагаа зэрэг болно. Уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгийн байдал нэмэгдэж байгаа нь хот руу чиглэсэн хяналтгүй шилжилт хөдөлгөөнд хүргэж, хотын хөрөнгө нөөцөд улам их хүндрэл учруулж, улс орон даяар интеграцийн асуудлыг хурцатгаж байна. Хэдийгээр уул уурхайн салбар нь эдийн засгийн гол хөдөлгөгч хүч хэвээр байх ч тус банк нь Монгол Улсад цаашид төрөлжүүлэлт, харилцаа холбоог бэхжүүлэх, бүс нутгийн интеграцлал, ногоон эдийн засагт шилжих шилжилтийг хурдасгах замаар холбогдох мөчлөгийг даван туулахад тусалж чадна.

Хэрэгжилтэд тулгарч буй асуудлууд

- Банкны салбарын хэт төвлөрсөн байдал, барьцаа хөрөнгийн хатуу нөхцөл, банкны салбарын шинэчлэлийн тодорхойгүй байдал, ялангуяа ЖДУ-д хязгаарлагдмал зээл өгдөг байдаг.
- Засгийн газар байнга солигдож, бодлогын уялдаа холбоогүй байгаа нь эрчим хүч, дэд бүтцийн салбарын төслүүдийг хойшлуулж, гадаадын хөрөнгө оруулалтад саад учруулж байна.
- ТХХТ-ийн төслүүд дутмаг, засгийн газрын зээл авах чадавхи хязгаарлагдмал байгаа нь хөрөнгө оруулалтын, ялангуяа дэд бүтцийн ихээхэн дутагдалд хүргэсэн.
- Таналт болон Эрчим хүч худалдан авах гэрээний нөхцөлийг дахин хэлэлцэхтэй холбогдуулан үүссэн тодорхойгүй байдал нь сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг улам хүндрүүлсэн.
- Хувийн үйлдвэрлэлийн салбарын жижиг хэмжээ, ЕСБХБ-ны ихэнхи үйлчлүүлэгчид ЖДУ эрхлэгчид байдаг нь үйлчилгээний үр ашигтай ажиллагаанд бэрхшээл үүсгэж, том хэмжээтэй олборлох салбартай харьцуулбал эдийн засгийн төрөлжүүлэлтийн нөлөөг хязгаарладаг.

Гол сургамжууд, цаашдын төлөв

- Эрсдэл хуваарилах систем болон Санхүүгийн зуучдын тогтолцооны хэрэглээг өргөжүүлж, банкны салбарын шинэчлэлийг дуусгахын тулд Засгийн газар, Монголбанкттай бодлогын хамтын ажиллагаагаа үргэлжлүүлнэ.
- Шинэ сэргэлтийн бодлого, Алсын хараа-2050 зэрэг Засгийн газрын бодлогын дагуу стратегийн ач холбогдолтой салбарын техникийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд одоогийн улс төрийн тогтвортой байдлыг үр ашигтай ашиглах, эрх баригчидтай тогтоосон харилцаагаа ашиглахыг эрмэлзэнэ.
- Засгийн газрын ТХХТ-ийн шинэчлэгдсэн амлалт болон ТХХТ-ийн шинэ хууль тогтоомж нь Шинэ сэргэлтийн бодлогын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг (ялангуяа дотоодын) хэрэгжүүлэх боломжийг олгоно.
- Сэргээгдэх эрчим хүчний асуудлаар Засгийн газартай яриа хэлэлцээгээ үргэлжлүүлж, сэргээгдэх эрчим хүчний шинэ төслүүдийг багасгах, тендер зарлах асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд эрх баригчид болон ОУСБ-тай хамтын ажиллагаагаа нэмэгдүүлнэ.
- Түнш банкууд, ББСБ-ын сүлжээг өргөжүүлж, өсч өргөжих өндөр чадамжтай ЖДУ эрхлэгчдэд хүрч үйлчлэх боломжийг нэмэгдүүлэх шинэ Финтек шийдлүүдийг судална.

2. Эдийн засгийн нөхцөл байдал



European Bank
for Reconstruction and Development

2.1 . Макро эдийн засгийн нөхцөл байдал, хэтийн төлөв

Монгол Улс – Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

	2018	2019	2020	2021
ДНБ-ний өсөлт (% жилээс жилд)	6.9	5.6	-4.6	1.4
ХҮИ-ийн инфляци (% дундаж)	6.8	7.3	3.7	7.1
Засгийн газрын үлдэгдэл (% ДНБ-ний)	2.9	0.9	-9.4	-3.1
Урсгал дансны үлдэгдэл (% ДНБ-ний)	-16.7	-15.2	-5.1	-13.0
Цэвэр ГШХО (% ДНБ- ний) [хасах нь орж ирж буйг илэрхийлнэ]	-14.9	-17.6	-8.0	-14.0*
Гадаад өрийн нөөц (% ҮНБ-ний)	249.4	250.5	275.8	N/A
Нийт валютын нөөц (% ДНБ-ний)	27.1	31.4	28.9	28.9
Засгийн газрын нийт өр (% ДНБ-ний)	88.2	78.5	91.3	94.7
Ажилгүйдлийн хэмжээ (%)	7.8	10.0	7.0	6.3
Нэрлэсэн ДНБ (\$тэрбум)	13.1	14.2	13.3	15.1

- **2010-2019 оны хооронд Монгол Улс** уул уурхайн салбарын нөлөөгөөр (шууд болон шууд бусаар үржигдэхүүний нөлөөгөөр) жилийн дундаж өсөлт нь 7.8 хувитай **дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж буй эдийн засагтай орнуудын нэг байсан**. 2000-аад оны эхэн ба дунд үе дэх БНХАУ-ын эдийн засгийн хурдацтай өсөлт нь зэс, коксжих нүүрс, төмрийн хүдэр зэрэг түүхий эдийн дэлхийн зах зээл дэх үнийг огцом өсгөж, улмаар Монголын ГШХО болон экспортын хурдацтай өсөлтийг бий болгосон.
- **Цар тахлын улмаас 2020 онд эдийн засаг нь 5.3 хувиар агшсан**. Уул уурхай, бөөний болон жижиглэнгийн худалдаа, тээвэр хамгийн их хохирол амссан нь эдийн засгийн уналтад тус тус -2.0 хувиас -1.3 хувь болон -1.5 хувиар нөлөөлсөн. 2020 онд өсөлттэй байсан цорын ганц салбар нь хөдөө аж ахуй байв.
- **2021 онд Монгол Улс** эпидиомологи, хилийн хязгаарлалт үргэлжилсэн нь **экспортын хэмжээ ихээхэн буурахад** хүргэсэн. Гэсэн хэдий ч экспортын гол нэрийн бүтээгдэхүүний (нүүрс, зэс) үнийн таатай нөхцөлийн улмаас Монгол Улс экспортын өндөр орлоготой байсан нь эдийн засгийг 1.4 хувиар сэргээх боломжийг олгосон.
- **Тус улс нь их хэмжээний өрийн дарамтад байгаа бөгөөд богино хугацаанд хөрөнгийн хөрвөх чадвар хүнд хэвээр байна**. Гэсэн хэдий ч татвар, төсвийн сахилга батыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр төсвийн алдагдал 2020 онд ДНБ-ий 9.4 хувьтай байсан бол 2021 онд ДНБ-ий 3.1 хувьд хүрсэн. Монгол Улсын гадаад өртэй холбоотой эрсдлийг хөнгөлөлтийн зээлийн эзлэх өндөр хэмжээ болон ирээдүйд өсөн нэмэгдэх экспортын орлого бууруулж өгч байна. Энэ нь хөрөнгийн зах зээлд тус улсын бонд, үнэт цаасыг худалдаж авах өндөр эрэлтийг бий болгох юм. Засгийн газар Рио Тинто той тохиролцоонд хүрснээр Оюутолгойн далд уурхайн өргөтгөлийн ажлыг эхлүүлж, энэ нь ирээдүйд орж ирэх ГШХО-д учрах эрсдэлийг бууруулж, 2023 онд олборлолтыг нэмэгдүүлэх боломжийг олгож байна.
- **2021 онд эдийн засаг бага зэрэг сэргэж, 2022 онд илүү сэргэх төлөвтэй байна**. ОХУ-ын Украйнтай хийсэн дайн нь хүнс, шатахууны үнийн өсөлт, ОХУ-ын банкуудад төлөх төлбөр тооцоо болон өмнө нь ОХУ дахь төвлөрсөн төвүүдээр дамжуулан түгээдэг байсан эсхүл ОХУ-аар дамжин тээвэрлэдэг бараа бүтээгдэхүүнийг өөр замаар ханган нийлүүлэхтэй холбоотой түр зуурын хүндрэл бэрхшээлээс өөр байдлаар Монгол Улсад шууд нөлөөлөл үзүүлээгүй. Гэсэн хэдий ч худалдааны логистикийн асуудал хүндрэлтэй хэвээр байна. БНХАУ-ын Тяньжин боомтод гацсан чингэлзгийн тоо багассан ч Улаанбаатар болон Монголын хилийн боомтуудад ихээхэн саад, гацаа үүссэн. Гэхдээ Тавантолгой, Оюутолгойн уул уурхайн төслүүд болон төмөр зам, газрын тос боловсруулах зэрэг бусад нэн чухал дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалт үргэлжилж, аялал жуулчлалын үйл ажиллагаа бүрэн сэргэж чадвал 2023 оны хэтийн төлөв сайжрах боломжтой.

Эх сурвалж: Дотоодын байгууллагууд, ОУВС

* 2021 оны зарим үзүүлэлтүүд нь урьдчилсан буюу ОУВС-гийн тооцоонд үндэслэсэн болно.

PUBLIC

2. Эдийн засгийн нөхцөл байдал

2.2 . Шилжилтийн гол асуудлууд




European Bank
for Reconstruction and Development

Өрсөлдөх чадвар (4.2)

- Эдийн засаг хангалтгүй төрөлжүүлэлтээс болж хохирч, уул уурхайн экспортын өсөлт, ялангуяа бүтээгдэхүүний олон төрөл багатай байдал нь дэлхийн хамгийн бага төрөлжсөн экспорттой улсын нэг болоход хүргэсэн.
- Тээврийн дэд бүтэц муу, логикийн хязгаарлагдмал байдал нь Монголын бизнесийн орчинд томоохон саад учруулж, худалдааны өндөр өртөгөөс шалтгаалж тус улсын өрсөлдөх чадварыг бууруулж байна.
- Сүүлийн 10 жилд хотжилт, гадаадын хөрөнгө оруулалт, ялангуяа уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтын нэмэгдсэн нь хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэхэд хүргэсэн.
- Гэхдээ олон их, дээд сургууль, ТМБС-ын хөтөлбөрүүд байгаа хэдий ч Монголын хөдөлмөрийн зах зээлд ур чадвар, мэдлэг дутмаг хэвээр байгаа нь боловсролын тогтолцоо, тэр дундаа сүүлийн үед шилжин суурьшигчид болон залуучуудад чиглэсэн ур чадварыг дээшлүүлэх, давтан сургах хөтөлбөрүүдийг ихээхэн сайжруулах шаардлагатай байна.

Эдийн засгийн олон хэсгээс бүрдсэн байдлын индекс ба дэлхийн үнэ өртгийн сүлжээн дэх оролцоо, ур чадвар




Source: CID Harvard The Atlas of Economic Complexity

Сайн засаглал (4.92)

- 2021 он хүртэл Засгийн газар ойр ойрхон солигдож, бодлогоо өөрчилж байсан нь засгийн газрын үр нөлөөг бууруулж, Монгол Улсын өсөлтийн боломжуудыг ашиглах чадварыг бууруулсан. Монгол Улс 2016-2020 онд ДБ-ны Дэлхийн засаглалын үзүүлэлтээр бараг 10 хувиар буурч, хөрш орнуудаасаа хоцорч байна.
- Шилжилтийн эхэн үед амжилттай байсан ч Монгол Улс өмчлөх эрхийг бүрэн хангаагүй бөгөөд дэлхийн дунджаас доогуур байна. 2021 оны Эдийн засгийн эрх чөлөөний индексээр Монгол Улс 184 орноос 103-т жагссан нь засгийн газраас хөрөнгө албадан хурааж авах магадлал өндөр байгааг харуулж байна.
- Шүүгчийн томилооны ил тод байдлыг нэмэгдүүлэх, улс төрийн нөлөөллийг бууруулах хүчин чармайлтыг сүүлийн үед гаргаж байгаа хэдий ч шүүхийн тогтолцоог цаашид шинэчлэх шаардлагатай байна.
- Монгол Улс 2020 оны авлигын индексээр 179 орноос 111-д жагссан. Авлига зөвхөн төрийн захиргааны төв байгууллагаар хязгаарлагдахгүй, орон нутагт ч мөн өргөн тархсан.

Засаглалын үзүүлэлтүүд




Source: World Bank's Worldwide Governance Indicators 2020

Ногоон (4.75)

- Нүүрс нь эрчим хүчний хангамж, тэр дундаа төвлөрсөн дулаан хангамжийн гол эх үүсвэр байсаар ирсэн. 2018 онд СЭХ-ний эх үүсвэрээс цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд 1 хувиас бага хувийг, харин нүүрс нийт үйлдвэрлэлийн 88 хувийг тус тус эзэлж байв.
- 2018 онд эрчим хүчний эцсийн хэрэглээний хамгийн их хэмжээг аж үйлдвэрийн салбар (32%), орон сууцны салбар (26%), тээвэр (19%) болон бусад салбар (23%) эзэлж байсан
- Хөдөө аж ахуйн салбар нь 2018 онд хүлэмжийн хийн ялгаралтын 55 орчим хувийг бүрдүүлсэн бөгөөд түүхэндээ хамгийн том ялгаруулагч байсан.
- Агаарын бохирдол нь хот суурин газрын байгаль орчны ноцтой асуудал бөгөөд Монгол Улсын хүн амын нас баралт, хөгжлийн бэрхшээлийн эхний 10 шалтгааны нэг юм.
- Монголын хог хаягдал болон бохир усны салбарт хөрөнгө оруулалт дутмаг байна.

CO2 ялгарлын хэмжээ (kgCO2/2015 ам.доллар)



Source: IEA. Note: Emissions from fuel combustion

2. Эдийн засгийн нөхцөл байдал


2.2. Шилжилтийн гол асуудлууд



European Bank
for Reconstruction and Development

Оролцоо (5.27)

- Өмчийн эзэмшигч, менежерүүдийн 44 орчим хувь нь эмэгтэйчүүд байгаа нь ЕСБХБ болон Төв Азийн дунджаас илүү байна.
- Залуучуудын (15-24 насны) ажилгүйдэл бусад хөдөлмөрийн насны хүн амын хэмжээнээс бараг гурав дахин их байгаа нь Төв Азийн бүх улс орнууд дунд хамгийн муу үзүүлэлттэй байна.
- Ажил олгогчид үндэсний боловсролын тогтолцоог харьцангуй чанар муутай гэж үзэж байгаа нь ур чадварын зөрүүтэй байгаа асуудлыг шийдэж чадахгүй байна.
- Монгол Улс бусад хөгжиж буй зах зээлтэй харьцуулахад элсэгчдийн тоо болон албан ёсны сургалтын жилийн хувьд харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Боловсролын систем нь чанарын хувьд тийм ч сайн биш байгаа нь сургалтын онцлогт тохируулсан сургалтын жилийн зөрүүгээс харагдаж байна.
- Усны хүртээмжийн хувьд бүс нутгийн хувьд ихээхэн ялгаатай байна. Орон нутгийн хүн амын дөнгөж 61 хувь нь ундны усаар хангагдаж байгаа бол хот суурин газарт бараг бүх нийтээр хангагдаж байна.




Source: EBRD Transition Report 2021-2022

Тогтвортой (5.47)

- Санхүүгийн салбарт банкны салбар зонхилж байна (санхүүгийн салбарын активын 87 хувь). Хамгийн том гурван банк нь банкны нийт активын 70 гаруй хувийг эзэлж байгаа нь хэт төвлөрлийг харуулж байна.
- Бүс нутгийн бусад улс оронтой харьцуулахад зээл авах боломж өндөр байгаа ч санхүүжилт авах хүртээмж нь Монголын компаниудын хувьд хамгийн том бэрхшээл байсаар байна. Барьцаа хөрөнгийн хэт өндөр шаардлага (40-60 хувь) болон өндөр зээлийн хүү зэрэг нь ЖДҮ эрхлэгчдэд хамгийн их тулгардаг асуудал юм.
- Эдийн засаг нь олон улсын түүхий эдийн зах зээл дэх үнийн хэлбэлзэл болон аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбарын улирлын болон цаг агаарын өөрчлөлтөд өртөмтгий байдаг. Засгийн газрын болон хувийн хэвшлийн өрийн хэмжээ нэмэгдсэн нь нөхцөл байдлыг улам хүндрүүлж байна.
- ОХУ-аас өндөр үнэтэй цахилгаан эрчим хүч импортлодог, эцсийн хэрэглэгчийн тариф багатай байдгийн улмаас эрчим хүчний тогтолцоонд эрчим хүчний алдагдал өндөр, дулааны үр ашиг бага, ашиглалтын түвшин багатай байдаг онцлогтой.

Банкуудын хувийн хэвшилд олгосон дотоодын зээл % ДНБ-ний, 2019




Source: WB WDI

Нэгдмэл (4.88)

- Тус улс нь хоёр талын 40 хөрөнгө оруулалтын гэрээнд нэгдэж орсон байгаа нь ЕСБХБ-ны дунджаас доогуур хэдий ч Төв Азийн орнуудын дунджаас дээгүүр байна.
- Зам тээврийн чанарын хувьд ЕСБХБ-ны орнууд дундаас хамгийн доогуур (38 орноос 34-т) байгаа бол агаарын тээвэр, далайн боомтын үйлчилгээний үр ашиг, хүртээмж нь мөн дунджаас доогуур байгааг ДЭЗФ-ын Дэлхийн өрсөлдөх чадварын индекс харуулж байна.
- Логистикийн гүйцэтгэлийн индексийн оноо нь ЕСБХБ-ны дунджаас ихээхэн доогуур байна. Дэд бүтцийн чанар, илрүүлж олох, хянах чадвар, ложистик болон гаалийн чанараар ЕСБХБ-ны бүс нутагт хамгийн доогуур байрыг эзэлж байна.
- Цахилгаан эрчим хүч дамжуулах, түгээх алдагдлын хэмжээ нь ЕСБХБ-ны дунджаас бага хэдий ч цахилгаан эрчим хүч авахад шаардагдах хугацаа нь Төв Ази болон ЕСБХБ-ны бүс нутгийн дунджаас дээгүүр байна.

Логистикийн гүйцэтгэлийн индекс, 2018



Source: WB LPI

3. Засгийн газрын тэргүүлэх чиглэл, оролцогч талуудын үүрэг оролцоо



European Bank
for Reconstruction and Development

3.1. Засгийн газрын шинэчлэлийн тэргүүлэх чиглэлүүд

Засгийн газраас 2020 оны 5 дугаар сард тогтвортой хөгжлийн зарчмуудыг урт хугацааны бодлогодоо тусгаж, эдийн засгийг Ковид-19 цар тахлаас сэргээхэд туслах “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогоо танилцуулсан. Алсын хараа-2050 нь улс орны нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, амьдралын чанарыг өөрчлөхөд чиглэсэн 9 зорилтыг дэвшүүлсэн. Эдгээр нь:

- **Хүний хөгжил, амьдралын чанар:** Боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж, нийгмийн хамгаалмыг өргөжүүлэх; олон улсад өрсөлдөхүйц инновацийн сүлжээг хөгжүүлж, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох; бизнесийн ур чадварын хөгжүүлэх; иргэн төвтэй засаглалаар дамжуулан тэгш боломж, эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг дэмжинэ.
- **Эдийн засаг:** хүртээмжтэй, олон улсад холбогдсон санхүүгийн системтэй тогтвортой, экспортод чиглэсэн эдийн засгийг дэмжих; эдийн засаг, худалдааны интеграцлал болон ЖДҮ-ийн өрсөлдөх чадварыг сайжруулах; эдийн засгийг төрөлжүүлэх, инновац, хүний болон ногоон хөгжлийг дэмжих зорилгоор баялгийн сан байгуулана.
- **Сайн засаглал:** төрийн захиргааны байгууллагын эрх мэдэл, чиг үүргийн тэнцвэрийг оновчтой болгож, тогтвортой засаглалыг бүрдүүлэх, шүүхийн тогтолцоог бэхжүүлэх; үр дүнтэй цахим засаглалын тогтолцоог хөгжүүлж, төрийн албаны ил тод байдлыг нэмэгдүүлэх; иргэний нийгэм-төр-хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлнэ.
- **Ногоон хөгжил:** байгалийн нөөцийг нөхөн сэргээх, усны хомсдлоос урьдчилан сэргийлэх, гадаргын усыг хуримтлуулах замаар анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг дэмжих; утаа багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- **Бүсчилсэн хөгжил:** бүс нутгийг дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр холбох замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих нөхцөлийг бүрдүүлэх; тэргүүлэх салбаруудад тулгуурласан орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх; байгаль орчинд ээлтэй, тэсвэртэй, хариуцлагатай, өндөр бүтээмжтэй хөдөө аж ахуйг хөгжүүлнэ.
- **Улаанбаатар ба дагуул хот:** Зүүн хойд Азийн тээвэр, ложистик, олон улсын зангилаа болох тогтвортой хууль эрх зүйн орчин, сайн засаглал бүхий тэнцвэртэй экосистем болон өргөжин тэлэх дагуул хотууд бүхий олон улсад өрсөлдөх чадвартай метрополитан бүсийг хөгжүүлнэ.

Бодлогын хэрэгжилтийг (i) хил, харилцаа холбооны чадавхийг нэмэгдүүлэх, (ii) аж үйлдвэрийн технологийг шинэчлэх, (iii) бүс нутгийн интеграцлал, (iv) эрчим хүчний дамжуулалт, түгээлтийн сүлжээг сайжруулах, (v) уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээ авах, (vi) засгийн газар болон ТӨҮГ-ын үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөр болох “Шинэ сэргэлтийн бодлого”-д зарим байдлаар тусгагдсан болно.

3.2. Эрх баригчидтай ерөнхийд нь тохиролцсон ЕСБХБ-ны шинэчлэлийн чиглэлүүд

Дараах чиглэлүүд нь Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлого, “Алсын хараа – 2050” хөгжлийн бодлоготой нийцэж байгаа болно. Үүнд:

- Хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, гадны хүчин зүйлийг даван туулахад нь туслах зорилгоор ЖДҮ-ийн салбарыг дэмжихийн зэрэгцээ ложистик, хүний нөөц зэрэг голлох салбаруудыг сайжруулах.
- Хөдөө орон нутагт кибер аюулгүй байдал, цахим үйлчилгээний хамрах хүрээг бэхжүүлэх замаар дижитал үйлчилгээ, дэд бүтцийг сайжруулах, дижитал үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.
- Улсын хэмжээнд сэргээгдэх эрчим хүчний цаашдын хөгжлийг дэмжих, үүнд хууль эрх зүйн тогтолцоог шинэчлэх, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах болон эрчим хүчний сүлжээ, холболтын үр ашгийг нэмэгдүүлэх, өгөгдөл хадгалалтын шинэлэг шийдэлд хийх хөрөнгө оруулалтыг дэмжих.
- Ногоон шилжилтийг дэмжихэд нүүрстөрөгчөөс ангижруулах урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, хүлэмжийн хийн ялгаруулалтыг тэг түвшинд хүргэх бодлогыг хэрэгжүүлэх.
- Зам, тээврийн сүлжээ, ложистикийн дэд бүтцэд нэмэлт хөрөнгө оруулалт хийх замаар бүс нутгийн хөгжил, дотоодын харилцаа холбоог сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

3.3. Иргэний нийгмийн зүгээс ЕСБХБ-д ирүүлсэн гол саналууд

- Ил тод байдлыг нэмэгдүүлэх, хувь хүнийг чадавхижуулах, бизнес эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн мэдээллийн сүлжээг бэхжүүлэх замаар Монгол Улсын тогтвортой байдал, эдийн засгийн засаглалыг сайжруулахад чиглэсэн ЕСБХБ-ны санал болгож буй стратегийн чиглэлийг ТББ-ууд талархан хүлээн авав.
- Эмэгтэйчүүд, залуучуудын оролцоог дэмжих гол хүчин зүйл нь бүс нутгийн тэгш бус байдлыг бууруулах, харилцаа холбоог сайжруулах гэдэг тус банкны тэргүүлэх чиглэлийг ТББ-ууд дэмжсэн. Тодруулбал, ЕСБХБ-ны санал болгож буй бизнесийн загваруудыг сайжруулах, цаашид залуу бизнес эрхлэгчдийг хамруулах боломжтой байхаар эмэгтэйчүүд тэргүүтэй аж ахуйн нэгжүүдийг цахимжуулах хөтөлбөрийг өргөжүүлэх зорилтыг ТББ-ууд сайшаав. Улс орны хүн ам зүйн онцлогийг харгалзан залуучуудын мэргэжил дээшлүүлэх санаачлагыг дэмжих нь чухал гэж үзсэн.
- ТББ-ууд мөн ЕСБХБ-ны улс орны ногоон эдийн засагт шилжих үйл явцыг хурдасгах төлөвлөгөөг өндрөөр үнэлж, хөдөө орон нутгийн иргэд болон залуучуудыг татан оролцуулах замаар байгалийн өвөрмөц нөөц баялгийг хадгалахын чухлыг онцлон тэмдэглэв.

4. ЕСБХБ-ны Монгол дахь стратегийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох нь



European Bank
for Reconstruction and Development

Юуг өөрчлөх шаардлагатай вэ? (Улс орны оношилгоо)

- Олборлох үйлдвэрүүдийн зэлэх хувь өндөр байгаа тул эдийн засаг нь өсөлт, уналтын мөчлөгт өртөөн хэвээр байна.
- Албан ёсны ажил эрхлэлтийн зэлэх хувь (50%) нь Төв Азидаа хамгийн бага байгаа бөгөөд улирлын чанартай ажил эрхлэлт нь ур чадварын хөгжил, хөрөнгийн хуримтлалд саад учруудаг.
- Банкны салбар өндөр төвлөрөлтэй бөгөөд ЖДҮ-г эрсдэлтэй гэж үздэг
- ЖДҮ-үүд нийт ажиллах хүчний 40 хувийг бүрдүүлдэг ч ДНБ-ий 1/6-г л үйлдвэрлэдэг.
- Ур чадвар муутай ажиллах хүч, хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нь хөдөлмөр эрхлэлтийг албан бус, бүтээмж багатай үйлчилгээний салбар руу шилжихэд хүргэж байна.

Юуг өөрчлөх боломжтой вэ? (Улс төрийн эдийн засаг)

- Улс төрийн тогтвортой байдал нэмэгдэх хэтийн төлөвтэй, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт зэрэг
- Засгийн газар баялгийн эргэлтийн оргил үе, уналтын үеийг зохицуулах баялгийн сан байгуулах асуудлыг хэлэлцэж байна
- Нэгтүг өртгийн сүлжээг төрөлжүүлэлт, ногоон ажлын байрыг дэмжих нь аялал жуулчлал зэрэг гол салбаруудад байгаль суурилсан шийдлүүдийг бий болгоход түлэхц болно
- 2021 оны банкны шинэчлэл нь ил тод байдлыг нэмэгдүүлэх, төвлөрлийг бууруулах зорилготой
- Алсын хараа 2050 нь хүний хөгжлийг нэмэгдүүлэхэд (бүх иргэдэд чанартай боловсрол/хөдөлмөр эрхлэлтийг олгох гэх мэт) чиглэсэн.

Тус банк нь юу хийж чадах вэ? (Байгууллагын чадавхи)

- ЖДҮ болон аж ахуйн нэржүүдийг өсөж хөгжихөд нь туслах үр дүнтэй арга хэрэгслүүд (тухайлбал, нэмүү өртгийн сүлжээ, экспортын дэмжлэг) тусгайлан зээлийн шугам, шууд санхүүжилт (DFF, RSF) болон бага үйлчилгээ үзүүлдэг сегментэд зориулж зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэрэг болно
- Дотоодын мөнгөн тэмдэгтээр санхүүжүүлж, банкны зээл олголтыг сайжруулах
- Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, санхүүгийн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, тэр дундаа чадавхийг бэхжүүлэх чиглэлээр мэргэшсэн туршлагатай байх
- Бодлогын оролцоо нь бизнесийн уур амьсгалын цаашдын шинэчлэлийг дэмжиж, ЕСБХБ-ны оролцоо нь ГШХО-ыг татахад тусална.

Стратегийн тэргүүлэх зорилтууд (2022-2027)

Илүү хүчирхэг, төрөлжсөн, тогтвортой хувийн хэвшлээр дамжуулан Монгол Улсын тогтвортой байдлыг нэмэгдүүлэх

Юуг хүсэж байна вэ (Гол зорилтууд)

- Илүү өрсөлдөх чадвартай, тогтвортой хувийн хэвшил
- Санхүүгийн салбарыг бэхжүүлж, дотоодын мөнгөн тэмдэгтээр бүтээгдэхүүн хөгжүүлснээр тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ
- Засаглал, бизнесийн орчин сайжирна

- Дэд бүтцэд, ялангуяа тээврийн салбарт ихээхэн хоцрогдолтой байна, гэхдээ УБ, Эрдэнэт, Дархан хотоос гадна хүн амын нягтаршил бага байгаа нь тэргүүлэх ач холбогдол өгөхийн чухлыг харуулж байна.
- Монгол Улс ачаа тээврийн салбарт илүү их үүрэг оролцоотой байхын тулд төмөр замын хүчин чадалыг нэмэгдүүлэх шаардлагатай.
- Хилийн боомтууд дахь хүн хүчний чадавхи хангалтгүй, логикийн хүрэлцээ муу
- Цаг агаарын эрс тэс уур амьсгал (зуд), үер, мөнх цэвдэг хайлах зэрэг цаг уурын асуудлууд нь замын дэд бүтцийг гэмтээж, хот руу шилжих хөдөлгөөнд хүргэж байна.

- ОХУ, БНХАУ-ын хооронд байдаг газарзүйн байршил нь худалдааны боломжийг нэмэгдүүлж байгаа боловч зах зээлийг төрөлжүүлэх боломжийг хязгаарлаж байна
- Шинэ сэргэлтийн бодлого нь харилцаа холбоо, хилийн чадавхийг сайжруулах зэрэг хөгжлийн нэн тэргүүний зорилтуудыг онцолж буй
- Алсын хараа 2050 нь бүс нутгийн интеграцчлал, орон нутгийн хөгжил, тэр дундаа илүү тогтвортой хөдөө аж ахуйг чухалчилж үзсэн.
- Илүү аюулгүй, ногоон, тогтвортой хотын хөгжлийг бий болгох Засгийн газрын тэргүүлэх чиглэл
- Үйлчилгээний хүртээмжийг шинэчлэх, бүс нутгийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд дижитал өөрчлөлийг ашиглах боломжууд

- Бусад ОУСБ-тай хамт ЕСБХБ нь бүс нутгийн холбоо сүлжээ, оролцоог сайжруулахын тулд сонгосон тээврийн төслүүдийг санхүүжүүлэх боломжтой
- Логистикийг сайжруулах чиглэлээр ажиллаж байсан туршлагатай
- ЕСБХБ-ны хөрөнгө оруулалтыг хангалтгүй бүс нутгуудад хөрөнгө оруулалт хийх нь аялал жуулчлалыг нэмэгдүүлж, дэд бүтцийг сайжруулахын зэрэгцээ ажлын байрны ур чадварыг сайжруулах шийдлийг олоход туслах боломжтой, дижитал гэх мэт
- Дижитал шилжилтийн цогц арга барил, үүнд дэд бүтцийг хөгжүүлэх, шинэчлэх (тухайлбал, өргөн зурвасын шийдэл, цахим худалдааны платформ гэх мэт)

Өсөлтийг дэмжих, оролцоог нэмэгдүүлэхийн тулд харилцаа холбоо, бүс нутгийн интеграцчлалыг бэхжүүлэх

- Тээврийн дэд бүтцийн чанар, сүлжээ, хүртээмжийг сайжруулна
- Бүс нутгийн ялгааг багасгана
- Дижитал харилцаа холбоо сайжирна

- Эрчим хүчний бага тариф, ОХУ/БНХАУ-аас, өндөр үнэтэй импортлож байгаа нь ихээхэн татаастай Төвийн эрчим хүчний системд дарамт учруулж байна.
- Сэргээгдэх эрчим хүчний хүчин чадал нэмэгдэж байгаа хэдий ч ашиглалтын хүчин чадал хангалтгүйн улмаас маш бага хэвээр байна
- Хотын дэд бүтцийн чанар муу
- Экспортод боловсруулаагүй түүхийг эд зонхилж, ХБНХАУ-д ихээхэн төвлөрсөн (ялангуяа нүүрс)
- Гадаргын усны хомсдол нь усны тогтвортой байдлыг дасан зохицох тэргүүлэх чиглэл болгож байна
- Монгол Улс нь ЕСБХБ-ны бүс нутаг дахь нүүрсхүчлийн хийн агууламж хамгийн өндөртэй орны нэг юм.

- Ногоон хөгжил нь Алсын хараа-2050 бодлогын хүрээнд тэргүүлэх зорилтын нэг юм
- Тогтвортой хөгжил 2030-д сэргээгдэх эрчим хүчний зэлэх хувийг 30 хувиар нэмэгдүүлэх зорилт тавьсан байгаа нь биет/зохицуулалтын саад тогторыг арилгавал сэргээгдэх эрчим хүчний томоохон боломж бий.
- Засгийн газар хотын дэд бүтцийг сайжруулах, түүний дотор цахилгаан эрчим хүчний зорилтот шинэчлэлтийг нэн тэргүүнд тавьж байна
- Байгалийн баялгийн эзэмшил, зохицуулалт нь улс төрийн хүчтэй нөлөөтэй хэвээр байна
- Түүхэн бодлогын уялдаа холбоогүй байдал нь хөрөнгө оруулалтын орчинд нөлөөлсөн
- Монгол Улсын УХТХ-ийн зорилт 22.7 хувь байна.

- Төв Азид сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, илүү үр ашигтай үйлдвэрлэх, дамжуулах, түгээх ажлыг амжилттай хийсэн
- Ногоон хотыг оролцуулан донор байгууллагын санхүүжилтийг ашиглан тусгай зориулалтын НЭЗШ-ийн бүтээгдэхүүнээр дамжуулан хотын тогтвортой дэд бүтцийг хөгжүүлэх туршлагатай (энэ нь хот руу шилжих хөдөлгөөнд дасан зохицоход мөн тусална)
- ЕСБХБ-ны санхүүжилт/зөвлөх үйлчилгээ нь онц чухал түүхий эдийн тогтвортой олборлолтыг бэхжүүлж, нэмүү өртгийн сүлжээг нэмэгдүүлэхэд тусална.
- Нөөцийг үр ашигтай ашиглах, уур амьсгалд тэсвэртэй болгох, түүний дотор нүүрснээс салахад институцийн, санхүүгийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлнэ

Тогтвортой эрчим хүч, дэд бүтэц, уул уурхайгаар дамжуулан илүү ногоон, уур амьсгалд тэсвэртэй эдийн засгийг дэмжих

- Сэргээгдэх эрчим хүчний хүчин чадал нэмэгдэж, илүү тогтвортой эрчим хүчний сүлжээг бий болно
- Дэд бүтцийн чанар, үр ашиг, байгаль орчны тогтвортой байдал сайжирна
- Илүү тогтвортой уул уурхайн салбар
- Эрчим хүч, хөрөнгө нөөцийн үр ашиг, уур амьсгалд тэсвэртэй байдал нэмэгдэнэ

5. Үйл ажиллагааны бүтэц, үр дүн



European Bank
for Reconstruction and Development

Зорилт 1: Илүү хүчирхэг, төрөлжсөн, тогтвортой хувийн хэвшилээр дамжуулан Монгол Улсын тогтвортой байдлыг нэмэгдүүлэх

Үндсэн зорилтууд	Үйл ажиллагаа (Бүтээмж)	Хяналтын үзүүлэлтүүд (үр дүн)
Илүү өрсөлдөх чадвартай, тогтвортой хувийн хэвшил	- Хөдөө аж ахуй, аялал жуулчлал, үйлдвэрлэл зэрэг олборлох бус салбарын аж ахуйн нэгжүүд болон ЖДҮ эрхлэгчдэд шууд санхүүжилт олгох замаар эдийн засгийг төрөлжүүлэхэд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлж, экспортыг өргөжүүлэх, нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэхэд онцгойлон анхаарч, тусгайлан санхүүжилт, зөвлөгөө өгөх бүтээгдэхүүнээр хангана. - ЖБЗ хөтөлбөрөөр дамжуулан ЖДҮ-ийг өргөжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх (дигиталчлалыг оролцуулан), компанийн болон нийгмийн засаглал, санхүүгийн удирдлагыг бэхжүүлэх, экспортын бэлэн байдлыг нэмэгдүүлэх, цаашид бүс нутгийн ханган нийлүүлэлтийн сүлжээнд нэгдэхэд тус дөхөм болохуйц зөвлөгөө өгөх. - Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд чиглэсэн дэмжлэг үзүүлэх, үүнд нэгтгэгч, боловсруулагч нартай хамтран ажиллах, нэмүү өртөг шингэсэн санхүүгийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, хөрөнгө нөөцийг үр ашигтай ашиглах туршлагыг хэрэгжүүлэх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, ХДХ-өөр дамжуулан худалдааны санхүүжилтийг олгох. - Орон нутгийн банкууд/МСБ-уудтай эрсдэл хуваах механизм, зээлийн шугамыг эмэгтэйчүүд, залуучууд, хөдөө аж ахуйн бизнес, ногоон санхүүжилт зэрэг салбаруудад үргэлжлүүлэн нэвтрүүлэхийн зэрэгцээ банкуудын холбогдох чадавхийг бэхжүүлнэ. - Банкны Бизнес эрхэлдэг эмэгтэйчүүд хөтөлбөрийг өргөжүүлж, залуучуудад зориулсан ижил төстэй хөтөлбөрийг хөгжүүлэх, үүнд дигитал шийдлүүдийг дэмжих, бодлогын яриа хэлэлцээ явуулах замаар илүү таатай экосистемийг бүрдүүлэхийг зорино. - Байгууллагын үйлчлүүлэгчид болон сонгогдсон ЖДҮ-ийн хамтаар мэргэжлийн сургалт болон ур чадварыг хөгжүүлэх бусад санаачлагыг дэмжих, түүнчлэн ур чадварын дутагдлыг арилгах, илүү мэргэшсэн ажиллах хүчийг бий болгох тэгш боломжийг хангах бодлогыг дэмжинэ.	- ЖДҮ болон/эсхүл эмэгтэйчүүд тэргүүлсэн аж ахуйн нэгжүүдэд зориулж СТБ-аас олгосон - Экспорт эсхүл бүтээмж нэмэгдсэн гэж мэдээлсэн үйлчлүүлэгчдийн тоо - Сургалтын үр дүнд шинэ ур чадвар эзэмшсэн хүмүүсийн тоо (эм/эр)
Санхүүгийн салбарыг бэхжүүлж, дотоодын мөнгөн тэмдэгтээр бүтээгдэхүүн хөгжүүлснээр тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ	- Дотоодын мөнгөн тэмдэгтийн санхүүжилтийн хэрэглээг сайжруулах, тэр дундаа бодлогын зөвлөгөө өгөх замаар дотоодын мөнгөний зах зээлийн хөгжлийг үргэлжлүүлэн дэмжинэ. - Бичил санхүү/ББСБ-ын түншийн сүлжээгээр дамжуулан бичил болон жижиг бизнесийг санхүүгийн хүртээмжтэй болгоход дэмжлэг үзүүлнэ. - Шинэ эсхүл илүү боловсронгуй бүтээгдэхүүн (тухайлбал, ногоон бонд, корпорацийн бонд) нэвтрүүлэх замаар хөрөнгийн зах зээлийг цаашид хөгжүүлэх, IPO гаргах бэлэн байдал, хэрэглээний чадавхийг нэмэгдүүлэх, IPO хийх болон ТӨҮГ-ын хувьчлалтай холбоотой дотоодын хүч чармайлтыг дэмжих болон бусад арга замаар институцийн хөрөнгө оруулагчдын бааз суурийг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна. - Түнш байгууллагуудын хамт санхүүгийн хүртээмжийг сайжруулах боломжтой дигитал/финтек шийдлүүдийг судална - Банкны салбарын үндсэн шинэчлэлд чиглэсэн бодлогын оролцоог үргэлжлүүлэх, ялангуяа банкны өмчлөлийг төрөлжүүлэх тухай сүүлийн үеийн хууль тогтоомжууд, тэр дундаа тэргүүлэгч банкуудын IPO гаргах, хувьцааны эзэмшлийн төвлөрлийг бууруулах, түүнчлэн ерөнхийд нь банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын санхүүгийн хяналт, зохицуулалтын тогтолцоог сайжруулах, хөрөнгийн зах зээл ба эцсийн ашиг хүртэгч эзэмшигчийг тодорхойлох замаар санхүүгийн салбарыг бэхжүүлэхэд тусална.	- СТБ-аас дотоодын мөнгөн тэмдэгтээр олгосон зээлийн нийт тоо/хэмжээ - Хөрөнгийн болон мөнгөний зах зээл дэх хууль эрх зүйн болон зохицуулалтын сайжруулал
Засаглал, бизнесийн орчин сайжирна	- ГШХО болон хөрөнгө оруулагчдыг хамгаалах таатай орчныг сайжруулах (жишээ нь, дампуурлын тухай хууль болон шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийн хууль эрх зүйн болон зохицуулалтын шинэчлэл) ажлыг үргэлжлүүлэн дэмжиж, бизнесийн орчныг илүү үр ашигтай болгох цахим Монгол санаачилга зэрэг дигитал шийдлүүдийг ашиглах боломжийг эрэлхийлнэ. - ЖДҮ-ийн агентлаг, тэр дундаа ЖДҮ-ийн стратегийг боловсруулахад зөвлөх үйлчилгээ үзүүлнэ. - Төр, хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлэх, шаардлагатай тохиолдолд хэсэгчлэн буюу бүрэн хувьчлах байдлаар ТӨҮГ-ын засаглалыг сайжруулах, илүү арилжааных болгоход үргэлжлүүлэн дэмжинэ. - Үндэсний баялгийн сан, Хөгжлийн сангийн тухай хуулийг эцэслэх, батлах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Бизнесийн орчны хууль эрх зүйн болон зохицуулалтын сайжруулалт



5. Үйл ажиллагааны бүтэц, үр дүн

Зорилт 2: Өсөлтийг дэмжих, оролцоог нэмэгдүүлэхийн тулд харилцаа холбоо, бүс нутгийн интеграцлалыг бэхжүүлэх

Үндсэн зорилтууд	Үйл ажиллагаа (Бүтээмж)	Хяналтын үзүүлэлтүүд (үр дүн)
Тээврийн дэд бүтцийн чанар, сүлжээ, хүртээмжийг сайжруулна	- ОУСБ-ын түншүүдтэйгээ хамтран, гадаад өрийн чадавхийг харгалзан тээвэр, ложистикийн гол дэд бүтцийг, тэр дундаа дараах хөрөнгө оруулалтыг цаашид хөгжүүлэхийг эрмэлзэнэ. Үүнд: - нийтийн тээвэр, төмөр зам, хөдлөх хэрэгслийг шинэчлэх, өргөтгөх, - авто замын сүлжээг шинэчлэх (дотоод болон боломжтой бол хил дамнасан коридор) ба - бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд хил дамнасан логистик, харилцаа холбоо, агуулахын төвүүдийг сайжруулах, чадавхийг бэхжүүлэх, - боломжтой бол экспортыг нэмэгдүүлэх, хөрш орнуудтай харилцаа холбоогоо бэхжүүлэх, бүс нутгийн дотоод интеграцлал, оролцоог дэмжих, уур амьсгал, жендэрт нийцсэн загварыг тусгах, арилжааны болон/эсхүл хувийн хэвшлийн шийдлүүдийг ашиглах - Дээрхтэй уялдуулан дотоодын интеграцлал, хил дамнасан харилцаа холбоог бэхжүүлэх агаарын тээврийн салбарын боломжит боломжуудыг судлах.	- Банкны дэмжлэгтэй төслүүдээр дамжуулан тээврийн сүлжээний хүчин чадлыг сайжруулсан эсхүл нэмэгдүүлсэн - Тээврийн үйлчилгээний хүртээмж сайжирсан иргэдийн тоо
Бүс нутгийн ялгааг багасгана	- Алслагдсан бүс нутгаас малын гаралтай бүтээгдэхүүн авдаг хөдөө аж ахуйн агрегаторуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, чадавхийг бэхжүүлэх, түүнчлэн хуримтлуулах ажлыг сайжруулах үүднээс орон нутгийн боловсруулалт, хадгалалт, ложистикийн төвүүд зэрэг үйлчилгээ бага үзүүлдэг бүс нутагт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийг эрэлхийлнэ. - Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн засгийн газрын санаачилгыг дэмжих боломжийг судлах. - Ногоон хотууд төсөл зэргээр дамжуулан хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний урсгалд дасан зохицоход хотуудад туслах боломжуудыг эрэлхийлнэ. - Эргэн холбогдох харилцаа холбоо болон холбогдох дэд бүтэцтэй илүү олон төрлийн, тогтвортой, хүртээмжтэй аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх боломжийг эрэлхийлнэ.	Улаанбаатар хотоос бусад газарт хөдөө аж ахуйн бизнес, агрегатор ба/эсхүл боловсруулах үйлдвэр эрхлэгчдэд олгосон зээлийн нийт тоо/хэмжээ
Дижитал харилцаа холбоо сайжирна	- Дата төвтэй гар утас (4G/5G) болон өргөн зурвасын сүлжээ (жишээ нь, шилэн утас, дата төв, дундын дэд бүтэц), цахим худалдааны платформ, төлбөр тооцооны шийдлүүд болон мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг тоон дэд бүтэц, холболтыг нэмэгдүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны технологийн хүртээмжийг орон даяар нэмэгдүүлэх боломжит хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэн эрэлхийлэх - Төрийн үйлчилгээ, үйл явцыг цахимжуулахад дэмжлэг үзүүлэх боломжтой хөрөнгө оруулалт, зөвлөх үйлчилгээг судлах (тухайлбал, экспортыг бэхжүүлэх eTrade цахим худалдаа, онлайн зуучлал, нэхэмжлэлийн журам гэх мэт хуулийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх eJustice, eGovernment цахим засаглал болон e-Identity цахим үнэмлэх зэрэг) - Зөвлөх үйлчилгээгээр дамжуулан дижиталчлал, бизнесийг дижитал болгох дижитал сурталчилгаа/арилжааны хүчин чармайлтыг дэмжинэ.	- МХХТ-ийн дэд бүтэц, үйлчилгээний хүртээмж сайжирсан хүмүүсийн тоо - Шинэ дижитал технологи, бүтээгдэхүүн нэвтрүүлсэн хэрэглэгчдийн тоо



5. Үйл ажиллагааны бүтэц, үр дүн



European Bank
for Reconstruction and Development

Зорилт 3: Тогтвортой эрчим хүч, дэд бүтэц, уул уурхайгаар дамжуулан илүү ногоон, уур амьсгалд тэсвэртэй эдийн засгийг

д

Үндсэн зорилтууд	Үйл ажиллагаа (Бүтээмж)	Хяналтын үзүүлэлтүүд (үр дүн)
Сэргээгдэх эрчим хүчний хүчин чадал нэмэгдэж, илүү тогтвортой эрчим хүчний сүлжээг бий болно	- Сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг (ялангуяа нар, салхи) цаашид хөгжүүлэх, нийлүүлэх ажлыг шууд санхүүжүүлэх, бодлого/зөвлөх үйлчилгээ үзүүлэх дэмжлэгтэй хослуулан, дуудлага худалдааны тогтолцоог нэвтрүүлэх, одоогийн хязгаарлалтыг хууль эрх зүйн хувьд шийдвэрлэх механизмыг бий болгох зэрэг таатай зохицуулалтын орчныг бүрдүүлэх. - Сэргээгдэх эрчим хүчийг илүү сайн ашиглахын тулд сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэхэд туслах, үүнд ухаалаг сүлжээ, тоолуурын хэрэгсэл, одоо байгаа болон шинээр баригдах цахилгаан дамжуулах шугамд хөрөнгө оруулалт хийх, хадгалах, тэнцвэржүүлэх хүчин чадалд хөрөнгө оруулалт хийх боломжийг судлах. - Тасралтгүй эрчим хүчний эх үүсвэртэй ажиллах эрчим хүчний зохицуулагчийн чадавхийг бэхжүүлэхийг эрэлхийлэх. - Эрчим хүчний аюулгүй байдал, холболтыг сайжруулах хувилбаруудыг сонгон авч үзэж, нүүрстөрөгчөөс ангижрах, нүүрстөрөгч бага ялгаруулах арга замтай уялдуулан нүүрснээс татгалзаж, илүү цэвэр бүтээгдэхүүн рүү шилжихийг дэмжинэ.	- Сэргээгдэх эрчим хүчний нийт суурилуулсан хүчин чадал (МВт) - Нийт буурсан CO₂e (тонн/жилд)
Дэд бүтцийн чанар, үр ашиг, байгаль орчны тогтвортой байдал сайжирна	- Арилжааны болон байгаль орчинд ээлтэй хотын дэд бүтцийг санхүүжүүлэх, өөрөөр хэлбэл төвлөрсөн дулаан хангамж, хатуу хог хаягдал, ус/бохир ус, эмнэлэг, сургууль, хотын тээвэр, байгаль орчинд ээлтэй ногоон, хямд орон сууц, түүний дотор засгийн газрын шинэ төлөвлөлтийн хүрээнд боломжтой бол бонд гаргах замаар санхүүжүүлэх - Хотын захиргааны төслүүдийн санхүүгийн үр дүнтэй удирдлагыг дэмжихийн тулд (жишээ нь, тарифын шинэчлэл) дээр дурдсан зүйлсийг хотын захиргаанд техникийн тусалцаа үзүүлж, чадавхийг бэхжүүлэхтэй хослуулах. - Улаанбаатар хотын НХУАТ-г хэрэгжүүлж, Ногоон хотуудыг Эрдэнэт эсхүл Дархан хот руу өргөжүүлэх, үүнд хотын түвшинд нөлөөллийг бууруулах, уур амьсгалд тэсвэртэй болгох, дасан зохицох стратеги зэрэг асуудлыг авч үзэх. - Бүс нутагт илүү тогтвортой, эрчимжсэн газар тариалан ба/эсхүл усны хэрэглээ болон болзошгүй үерийн хамгаалалтад шилжих шилжилтийг хөнгөвчлөх усалгааны санхүүжилтийн хувилбаруудыг судлах.	- Үйлчилгээний хүртээмж сайжирсан хүмүүсийн тоо (ус, хатуу хог хаягдал) - Усны нийт хэмнэлт (м3/жилд)
Илүү тогтвортой уул уурхайн салбар	- Банкны Байгаль орчин, нийгмийн бодлогод нийцүүлэн, ёс суртахуун, аюулгүй байдал, байгаль орчны тогтвортой байдлын хамгийн өндөр стандартыг хангасан компаниудад (гадаадын нэр хүндтэй хөрөнгө оруулагчдыг оролцуулан) санхүүгийн болон институцийн дэмжлэг үзүүлэх замаар уул уурхайн тогтвортой салбарыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлсээр байна. Үүнд, ногоон эдийн засагт шилжихэд шаардлагатай металл болон тусгай ашигт малтмалын олборлолтын төслүүд, тухайлбал цахим хөдөлгөөнт байдал, эрчим хүчний хадгалалт зэрэг нэмүү өртөг шингэсэн экспортыг дэмжих зэрэг орно. - Уул уурхайтай холбоотой нэмүү өртгийн гинжин сүлжээг (тухайлбал, тоног төхөөрөмж, үйлчилгээ, логистик) үргэлжлүүлэн хөгжүүлж, уул уурхайн салбар болон холбогдох нийлүүлэлтийн гинжин сүлжээнд эмэгтэйчүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог нэмэгдүүлэх санаачилгыг дэмжинэ. - Тогтвортой, хариуцлагатай уул уурхайн салбарыг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэхэд бодлогын оролцоотой байх, үүнд засаглалыг бэхжүүлэх, ОУИТБС болон хөрөнгө оруулагчдыг дэмжих холбогдох зөвлөх үйлчилгээ зэрэг болно.	Засаглал, стандарт эсхүл үйл ажиллагаа сайжирсан нийт үйлчлүүлэгчдийн тоо (жишээлбэл, ил тод байдал, байгаль орчны тогтвортой байдал эсхүл тэгш боломж)
Эрчим хүч, хөрөнгө нөөцийн үр ашиг, уур амьсгалд тэсвэртэй байдал нэмэгдэнэ	- СТБ-уудтай эрчим хүчний хэмнэлт, нөөцийн үр ашгийг дээшлүүлэх зээлийн шугамаар дамжуулан ногоон шууд бус санхүүжилтийг (Жишээ нь НЭЗСХ) өргөжүүлж, бусад ногоон хөрөнгө оруулалт болон холбогдох хувийн хэвшлийн зөвлөх үйлчилгээг дэмжих. - Засгийн газарт нэмэлт ногоон хувийн хөрөнгө оруулалтыг тодорхойлох, санхүүжилт босгоход тусална. - Монгол Улсын ҮХЦ-ийн хэрэгжилтийг хангах, нүүрстөрөгчийн хий багатай, уур амьсгалд тэсвэртэй урт хугацааны эдийн засгийн хөгжлийг дэмжих арга замыг бусад хөгжлийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. - Салбар хоорондын дэд бүтцийн төслийг боловсруулахдаа байгаль орчны доройтлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй/дасан зохицох чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн засгийн газрын санаачилгыг дэмжихэд анхаарна	- Анхдагч эрчим хүчний нийт хэмнэлт(GJ/жилд) - Уур амьсгалд тэсвэртэй байдлыг дэмжих хууль эрх зүй, байгууллагын болон/эсхүл зохицуулалтын сайжруулалт



6. Олон улсын түншүүдийн ЕСБХБ-ны үйл ажиллагааны чиглэлүүд дэх нэмэлт оролцоог дүрслэн харуулах нь



European Bank
for Reconstruction and Development

ЕСБХБ-ны үйл ажиллагааны чиглэл														
		Салбар									Нийтлэг шинжтэй чиглэл			
		Аж үйлдвэр, худалдаа, хөдөө аж ахуйн бизнес					Тогтвортой дэд бүтэц		Санхүүгийн байгууллагууд		Стратегийн санаачилгууд			
Жилийн дундаж хөрөнгө оруулалт/буцалтгүй зээл (€сая, 2017-2021)		Хөдөө аж ахуйн бизнес	Үйлдвэрлэл ба үйлчилгээ	Үл хөдлөх хөрөнгө, аялал жуулчлал	Технологи, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо	Байгалийн баялаг	Эрчим хүч	Дэд бүтэц	Банк санхүү	Банк бус санхүүгийн байгууллагууд	Ногоон эдийн засаг	Оролцоо ба жендер	Дотоодын мөнгөн тэмдэгт ба хөрөнгийн зах зээл	Жижиг бизнес
АХБ*	244													
ЖАЙКА	87													
ДБ	80													
ОУСК	26													
ЕХ	11													
ФХА	7													
НБЭХБ	6													
ОУХА	5													
ЕСБХБ	105													

€ Их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн чиглэл

P Бодлогын ихээхэн оролцоотой чиглэл

Хувийн хэвшилд ихэвчлэн чиглэсэн

Төрийн салбарт ихэвчлэн чиглэсэн

Хамтын ажилагааны боломжит чиглэлүүд



Өрсөлдөх чадвартай:

- Уул уурхайн бус Экспортод чиглэсэн ЖДҮ-ийн салбарыг бэхжүүлж, цаашид хөгжүүлэх, бизнесийн орчныг сайжруулах зорилгоор ЕХ-той хамтын ажиллагаагаа өргөжүүлж, боломжит хамтарсан хөрөнгө оруулалтыг тодорхойлно.



Ногоон:

- Байгалийн нөөцийн тогтвортой менежмент, ногоон нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Европын санаачилгын хүрээнд зохицуулалтыг сайжруулна.



Нэгдмэл:

- Зам тээвэр, эрчим хүчний томоохон хөрөнгө оруулалтын хэрэгцээг шийдвэрлэхийн тулд АХБ болон ДБ-тай хамтран хөрөнгө оруулах боломжийг эрэлхийлнэ.



Тэсвэртэй:

- Бодлогын яриа хэлэлцээ, зөвлөмж, зорилтот хөрөнгө оруулалтыг хослуулах замаар өсөн нэмэгдэж буй гадаад эмзэг байдал, геополитикийн эрсдэл, ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээний тасалдлыг шийдвэрлэхийн тулд ОУСБ-тай уялдаа холбоог нэмэгдүүлнэ.



Оролцоог хангасан:

- Залуучууд болон хөдөө орон нутгийн иргэдийн бизнес эрхлэх боломжийг сайжруулах зорилгоор Европын баг болон бусад санаачлагуудаар дамжуулан ЕХ-той хамтын ажиллагаагаа үргэлжлүүлнэ

Тайлбар: Олон нийтэд нээлттэй мэдээлэлд тулгуурласан ОУСБ-ын зураглал (төсвийн дэмжлэгийг оруулаагүй) бөгөөд ОУСБ-ын томоохон хөрөнгө оруулалтыг 2017-2021 оны хооронд байгуулсан хөрөнгө оруулалтын 5 хувиас дээш гэж тодорхойлсон. *АХБ-ны 2017-2020 оны мэдээлэлд үндэслэсэн.

7. Хэрэгжилтийн эрсдэл, байгаль орчин, нийгмийн үрдагавар



European Bank
for Reconstruction and Development

Стратегийн хэрэгжилтэд учирч болох эрсдэл

Магадлал

Нөлөө

- **Макро эдийн засгийн эрсдэлүүд**, тухайлбал түүхий эдийн үнийн хэлбэлзэл, инфляцийн өсөлт, хилийн хаалттай байдал, ОХУ-ын Украйнд хийсэн дайны тодорхойгүй нөлөөлөл зэрэг нь цар тахлын дараах сэргэлтийг удаашруулж, макро эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй.
- **Нийлүүлэлтийн гинжин сүлжээнд саад, тасалдал үүсэх, төсвийн хязгаарлагдмал байдал**, төсвийн өрийн тогтвортой байдлын талаархи ОУВС-гийн зүгээс анхааруулж буй асуудал нь дэд бүтцийн төслүүд дэх төсвийн зарцуулалтыг бууруулахын зэрэгцээ тэдгээрийг санхүүжүүлэх банкуудын чадамжийг хязгаарлаж/хүндрүүлж, их хэмжээний буцалтгүй тусламж эсхүл хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт авах шаардлагыг бий болно.
- **Хөрөнгө оруулалтын орчны тогтворгүй байдал**, сүүлийн жилүүдэд засгийн газар байнга өөрчлөгдөж, бодлого өөрчлөгдөж байгаа нь гадаадын хөрөнгө оруулалт, ялангуяа уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг зогсоож болзошгүй.
- **ТХХТ-д ахиц гарахгүй байх, хязгаарлалтын асуудал болон санал болгож буй дуудлага худалдаа** зэрэг нь тус Банкны сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг урагшуулах боломжийг хязгаарлаж болзошгүй.
- Валютын своп зэрэг зах зээлд суурилсан арга хэрэгслээр дамжуулан **дотоодын мөнгөн тэмдэгтээр санхүүжилт хийх боломж хязгаарлагдмал байгаа** нь ЕСБХБ-ны аж ахуйн нэгж, ЖДҮ-д олгох зээлийг эрсдэлд оруулж болзошгүй.
- **Уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий байдал** нь хотын дэд бүтэц, хөдөө аж ахуйн бизнесийн төслүүдийн хөгжих чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй.



Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө

- **Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ, менежмент:** Төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх шууд, шууд бус болон нийт нөлөөллийг (жендэрийн нөлөөллийг оролцуулан) зохих ёсоор үнэлж, урьдчилан сэргийлэх, багасгах. Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө (жишээ нь биологийн олон төрөл зүйл, ус) болон стратегийн үнэлгээ бүхий зохицуулагчид, түүнчлэн олон улсын стандартын дагуу БОНУТ-ийг хэрэгжүүлэх, гэрээт гүйцэтгэгчдийг удирдахад төрийн байгууллагын үйлчлүүлэгчдэд ТХА-ны дэмжлэг шаардлагатай байж болно.
- **Хөдөлмөр ба хөдөлмөрийн нөхцөл:** Үйлчлүүлэгчдийн хөдөлмөрийн үйл ажиллагаа нь ЕСБХБ-ны PR2, ялангуяа цалин, тэтгэмж, хөдөлмөрийн нөхцөлтэй нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах; ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш боломжийг дэмжих; эвлэлдэн нэгдэх эрх чөлөө; болон өөрийн үйл ажиллагааны гэрээт гүйцэтгэгчид болон үндсэн ханган нийлүүлэгчдийн дунд хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх. Тус Банк нь жендэрт суурилсан хүчирхийлэл, дарамтаас (ЖСХД) урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад онцгой анхаарал хандуулж, зохих бодлого, хариу арга хэмжээ авах механизмыг боловсруулж хэрэгжүүлэхэд үйлчлүүлэгчдэд дэмжлэг үзүүлнэ. Төслийн ажилтнууд болон олон нийтийн дунд ЖСХД-ын эрсдэлийг шийдвэрлэхэд үйлчлүүлэгчдэд дэмжлэг үзүүлэхэд ТХА-ны санхүүжилт шаардлагатай байж болно.
- **Хөрөнгө нөөцийн үр ашиг ба бохирдлоос урьдчилан сэргийлэх, хяналт тавих:** Хог хаягдал, бохир ус, усны төслүүдийг тодорхойлж, боловсруулах, эргэлтийн эдийн засаг, нөөцийн үр ашгийг дэмжих, байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх хөрөнгө оруулалтыг тодорхойлох өөр хувилбаруудыг авч үзэх. Нүүрстөрөгч багатай, хөрөнгийн хэмнэлттэй эдийн засагт (салхи, нарны эрчим хүч, усны үр ашигтай хэрэглээ гэх мэт) шилжихийг дэмжиж, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг бэхжүүлэх. Хот суурин газрын агаарын чанарыг сайжруулахад чиглэсэн төсөл, ТХА нь нэн тэргүүний зорилт юм.
- **Эрүүл мэнд, аюулгүй байдал:** Уул уурхайн төслүүдэд БОНУТ-ийг ашиглах зэрэг бүх салбарт хөдөлмөр, нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартыг сайжруулахад чиглэнэ. Зам, хөдөлгөөний аюулгүй байдал нь тэргүүлэх чиглэл бөгөөд үйлчлүүлэгчид болон бусад гол оролцогч талуудтай хамтран ажиллах шаардлагатай байж болно. Стандартыг сайжруулах, мэдлэгийг дээшлүүлэхийн тулд ТХА-ны санхүүжилт шаардлагатай байж болно.
- **Газар худалдан авах, албадан нүүлгэн шилжүүлэх, эдийн засгийн шилжилт:** Газар худалдан авах, нүүлгэн шилжүүлэх шаардлагатай аливаа төсөл нь малчдын амьжиргааг хамгаалах, эмзэг бүлгийг хамгаалахад онцгой анхаарал хандуулж, Банкны нөхөн олговор олгох, амьжиргааг сэргээх шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулна.
- **Биологийн олон төрөл зүйлийг хамгаалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент:** Байгаль хамгаалахад чухал ач холбогдолтой төрөл зүйл, амьдрах орчныг хамгаалж, экосистемийн үйлчилгээ, байгалийн нөөц хөрөнгийн тогтвортой менежментийг баталгаажуулах үнэлгээтэй үйлчлүүлэгчдэд дэмжлэг үзүүлэх. Эдгээр үйл ажиллагааг дэмжихэд ТХА-ны санхүүжилт шаардлагатай байж болно.
- **Соёлын өв:** Орон нутгийн болон үндэсний ач холбогдол бүхий соёлын өв, үйлчилгээг хадгалах, зохих ач холбогдол өгөхийн тулд гол оролцогч талуудтай зөвлөлдөж, зохих үнэлэлт дүгнэлтийг өгөхийн тулд үйлчлүүлэгчидтэй хамтран ажиллана.
- **Санхүүгийн зуучлагчид:** СБ-ын түншүүд БОН-ийн зохих чадавхитай, эрсдэлийн удирдлагын журамтай байгаа эсэхийг шалгана.
- **Оролцогч талуудын оролцоо:** Төслийн үргэлжлэх хугацааны туршид олон нийтэд ойлгомжтой мэдээлэл, хүртээмжтэй зөвлөгөө өгөхийн тулд оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхэд үйлчлүүлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.

8. Донор байгууллагын хамтарсан санхүүжилтийн үнэлгээ

Шинэ стратегийн хугацаанд шаардлагатай үнэлгээ

Уг улс орны Стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хандивлагч байгууллагуудын санхүүжилт шаардлагатай, үүнд:

- Ногоон дэд бүтэц, сэргээгдэх эрчим хүч, хөрөнгө нөөцийн үр ашгийг хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжих буцалтгүй зээл, түүнчлэн зохицуулалтын таатай орчныг бүрдүүлэх бодлого, зөвлөх үйлчилгээ
- Тээвэр, эрчим хүч, ложистикийн гол дэд бүтцийг цаашид хөгжүүлэх, дотоодын/бүс нутгийн интеграцийг дэмжих хамтарсан хөрөнгө оруулалтын буцалтгүй зээл
- Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих шинэ арга хэрэгсэл, хууль эрх зүйн шинэчлэлийг нэвтрүүлж, зах зээлд (залуучууд, эмэгтэйчүүд, хөдөө аж ахуйн бизнес, ногоон санхүүжилт) хүртээмжийг нэмэгдүүлэх зөвлөх үйлчилгээг хослуулан.
- Цахим харилцаа холбоог нэмэгдүүлэх, улсын хэмжээнд хүртээмжийг нэмэгдүүлэх, зөвлөх үйлчилгээгээр дамжуулан төрийн үйлчилгээ, үйл явцыг цахимжуулахад дэмжлэг үзүүлэх буцалтгүй зээл.


Сонгосон боломжит үзүүлэлтүүд

ЕСБХБ-ны
бүс нутгийн хувь¹

Нэг хүнд ногдох ДНБ (ТХХТ, одоогийн \$) ²	12,862.7	38 th
ХАЁТ улс	Yes	N/A
ХАЁТ үндэсний нийт орлогод эзлэх хувь хэмжээгээр (%) ³	2.53	68 th
Нэг хүнд ногдох ХАЁТ (\$ одоогийн үнэ) ³	96.3	63 rd

1. Энгийн хувийн зэргийг ЕСБХБ-ны Монгол Улсаас доогуур байгаа орнуудын эзлэх хувь гэж үзүүлэв.
2. Эх сурвалж: ДХУ (2020 эсхл хамгийн сүүлийн боломжтой жил)
3. Эх сурвалж: ЭЗХАХБ (2019)
4. 2017-2021 оны ТХА-ны мэдээлэл нь төслийн түвшний зорилтууд дээр үндэслэсэн. Хамтарсан хөрөнгө оруулалтын буцалтгүй тээцийн хэмжээг үйлчилгээний гарын үсэг дээр үндэслэнэ.
5. 2020, 2021 онд олгосон (ТХА буцалтгүй зээлийн хувь) эсвэл үйлчилгээгидтэй байгуулсан (хамтарсан хөрөнгө оруулалтын буцалтгүй зээлийн хувь) буцалтгүй зээлийн Шийжилтийн үндсэн чанарт үндэслэнэ.

Сүүлчийн стратеги дэх хандивлагчдын санхүүжилт (€сая)⁴




PUBLIC

Донорын хөрөнгийн боломжит эх үүсвэрүүд

- ЕХ нь жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор эрсдэл хуваалцах хэрэгсэл, ТХА болон хөрөнгө оруулалтын сангуудын санхүүжилтийн өргөн хүрээтэй эх үүсвэр болох **ЖДҮ-ийг санхүүгийн хүртээмжтэй болгох замаар Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (ЕССМ) хөтөлбөрөөр** дамжуулан байнга хөрөнгө оруулалт хийдэг гол хандивлагч юм.
- Түүнчлэн, ногоон шилжилтийг дэмжих Олон талт уур амьсгалын сангууд байж болно. **Ногоон эдийн засгийн санхүүжилтийн хөтөлбөр нь (GEFF)** нь ногоон хөндлөнгийн зуучлалын санхүүжилтийг өргөжүүлнэ. **Ногоон уур амьсгалын санг (GCF)** цаашид ногоон хөрөнгө оруулалтад ашиглах боломжтой.
- Цаашид ч гэсэн **хоёр талын хандивлагчдаас** тусламж авахыг эрэлхийлэх болно. Япон Улс нь ихээхэн хувь нэмэр оруулсан бөгөөд Европын хамтын ажиллагааны бүс нутагт дотоодын мөнгөн тэмдэгтийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн туршлагатай. Мөн Тогтвортой дэд бүтцийн сан, Жижиг бизнест үзүүлэх нөлөөллийн сан зэрэг **Олон хандивлагчдын дансаар** дамжуулан санхүүжилт авах боломжтой.
- Хэдийнээ хамгийн том хандивлагч болсон **ЕСБХБ-ны Хувь нийлүүлэгчдийн тусгай сан** нь хангагдаагүй хэрэгцээ болон хандивлагчдын дэмжлэг (зарим бодлогын яриа хэлэлцээ болон засаглалын төслүүд) хоорондын зөрүүг арилгахад туслах нэмэлт санхүүжилтийн чухал эх үүсвэр болж ажиллах болно.

Use of grants in 2020-21⁵



Хавсралтууд



European Bank
for Reconstruction and Development

Хавсралт 1 – 1 дүгээр заалтын хүрээнд хийсэн улс төрийн нөхцөл байдлын үнэлгээ



European Bank
for Reconstruction and Development

Сүүлд 2017 оны 6 дугаар сард Улс орны хувьд баримтлах стратегийг баталснаас хойшхи хугацаанд Монгол Улс тус Банкныг байгуулах тухай хэлэлцээрт заасан 1 дүгээр заалтын зарчмуудыг баримталж, хэрэгжүүлсээр ирсэн. 1992 оны Үндсэн хуульд 1990 оны ардчилсан хувьсгалын зарчмуудыг тусгаж, “Хүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлоох”-ыг эрхэм дээд зорилго болгон тунхагласан. Монгол Улс 1 дүгээр заалтын зарчмуудыг баримталж ирсэн, олон намын тогтолцоотой ардчилсан улс гэдгээрээ Төв Азид ялгардаг.¹

Монгол Улс ардчилал, хүний эрхийн хэм хэмжээнд хяналт тавих үүрэг бүхий олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилладаг. 2020 оны 11 дүгээр сард НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэгт 3 дахь илтгэлээ хэлэлцүүлсэн. ЕХ-той жил бүр хүний эрхийн яриа хэлэлцээг зохион байгуулдаг. Ардчилал, хүний эрхийн хэм хэмжээг хөхиүлэн дэмжиж, хэрэгжүүлэхэд хяналт тавих үүрэг бүхий олон улсын байгууллагууд эдгээр чиглэлд Монгол Улсын ололт амжилтыг сайшаан үнэлсээр байна.²

Өмнөх улс орны стратегийн хугацаанд гарсан ахиц дэвшлийн хамгийн чухал нь 2019 оны 11 дүгээр сард УИХ-аас баталсан эрх мэдлийн хуваарилалт, шүүхийн хараат бус байдлын тухай Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой юм.

Эхэндээ, олон нийтээр хэлэлцүүлж, тухайн үеийн Ерөнхийлөгч Х.Баттулга Ерөнхийлөгчийн засаглалын тогтолцоонд шилжих санал гаргасны дараа Ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын даргад хохиролтойгоор Ерөнхий сайдын байр суурийг нэмэгдүүлж, эрх мэдлийн хуваарилалтыг илүү тодорхой, оновчтой болгох зорилгоор эцсийн багц нэмэлт, өөрчлөлтийг баталсан.

Хоёрдугаарт, Үндсэн хуульд шүүхийн хараат бус байдлыг тогтоосон тодорхой заалт байгаагүй. Энэ нь хөрөнгө оруулалтын орчин болон авлигатай тэмцэхэд сөргөөр нөлөөлж, улс төрийн нөлөөгөөр ялах заншлыг бий болгосон. Эцсийн батлагдсан багц нэмэлт, өөрчлөлтөд шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх арга хэмжээг мөн тусгасан.

Өмнөх Улс орны стратегийн хугацаанд анхаарал татсан гол асуудал нь авлигатай тэмцэх асуудалд ахиц дэвшил гараагүй байгаатай холбоотой юм. Монголын эрх баригчид илүү туштай хүч чармайлт гаргах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч бодитой арга хэмжээ хараахан аваагүй байна.

Чөлөөт сонгууль, төлөөмийн Засгийн газар

Чөлөөт, шударга, өрсөлдөөнтэй сонгууль

1992 онд баталж, 2000, 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомж нь чөлөөт, шударга, өрсөлдөөнтэй сонгууль явуулах үндэс суурийг тавьсан. Үндсэн хуулийн оршил хэсэгт “Ардчилсан ёсыг хангах” нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим гэж тунхагласан байдаг. 16 дугаар зүйлийн 9-д “Монгол Улсын иргэн шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй” гэж заасан.

2019 оны УИХ-ын сонгуулийн тухай хууль, 2020 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль нь олон улсын жишигт нийцэж байгаа хэдий ч ЕАБХАБ-ын Ардчилсан институц, хүний эрхийн албанаас (АИХЭА) эдгээр хуульд өгсөн зөвлөмжүүдийг одоог болтол тусгаагүй хэвээр байгааг тэмдэглэсэн.³ Өмнөх Улс орны стратегийг баталснаас хойшхи хугацаанд, энэхүү үндсэн хууль болон хууль, эрх зүйн зохицуулалтыг туштай, чадварлаг хэрэгжүүлж, Монгол Улсын иргэд төлөөмийн засаглалтай байх нөхцөлийг бүрдүүлсэн.

¹ НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссар Мишель Бачелет Монгол Улс хүний эрхийг хамгаалагчдын тухай хуулийг баталсны дараа хэлсэн үгэндээ “Ийм чухал хууль тогтоомжийг баталсан Ази тивийн анхны улс болохын хувьд уг хууль нь Монгол Улсын хийлийн дотор ч, хилийн чанадад ч цуурайтах болно” гэв. 2021 оны 4-р сарын 30-ны өдөр ОНЧР-ын цахим хуудсанд тавигдсан мэдэгдэл.

² 2021 онд Монгол Улс Freedom House-аас гаргасан Дэлхийн эрх чөлөөний судалгаанд Ази тив дэх “чөлөөтэй” гэсэн дөрвөн улсын нэгд багтсан.

Хавсралт 1 – 1 дүгээр заалтын хүрээнд хийсэн улс төрийн нөхцөл байдлын үнэлгээ



European Bank
for Reconstruction and Development

2017 оны 6 дугаар сараас хойш буюу 2017 оны 6-7 дугаар сард Ерөнхийлөгчийн сонгууль, 2020 оны 6 дугаар сард УИХ-ын сонгууль, 2021 оны 6 дугаар сард Ерөнхийлөгчийн сонгууль тус тус болсон. АИХЭА-наас 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Сонгуулийн ажиглалтын урьдчилсан судалгааны багийг илгээсэн бол 2020 оны УИХ-ын сонгуульд зөвхөн Үнэлгээний багийг, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Ковид цар тахлын улмаас Сонгууль ажиглах тусгай хорооны багийг илгээсэн.

АИХЭА-наас 2020 оны сонгуульд үнэлэлт дүгнэлт гаргаагүй ч 2017, 2021 оны сонгуулийн талаарх үнэлгээ нь ерөнхийдөө эерэг байсан. 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн тухайд “Сонгууль өрсөлдөөнтэй, зохион байгуулалт сайтай, сурталчилгаа богино боловч ширүүн боллоо” гэж дүгнэсэн. Эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг ерөнхийд нь хүндэтгэсэн.”⁴ 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн тухайд “сонгуулийг үр дүнтэй зохион байгуулж, нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаагаа чөлөөтэй явуулах боломжтой байсан” гэж дүгнэсэн хэдий ч нэр дэвшигчийн эрхийг хэт хязгаарлаж, сонгуулийн сурталчилгаа, хэвлэл мэдээллийн журмыг хязгаарласан нь сонгогчдын мэдээлэлтэй сонголт хийх чадварт сөргөөр нөлөөлсөн” гэдгийг онцлон тэмдэглэсэн.

Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцвэрийн үр дүнтэй тогтолцоо

Үндсэн хуулиар эрх мэдлийн хуваарилалт, хяналт тэнцвэрийн үр дүнтэй тогтолцоог бий болгосон. Монгол Улс нь Ерөнхийлөгч/парламентын засаглалтай холимог тогтолцоотой. 20 дугаар зүйлд Улсын Их Хурлыг хууль тогтоох эрх мэдлийг дангаараа хэрэгжүүлэх “төрийн эрх барих дээд байгууллага мөн” гэж тодорхойлсон. Хуулийн 30 дугаар зүйлд Ерөнхийлөгчийг “Төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн” гэж тодорхойлсон байдаг. 38 дугаар зүйлийн 1-д Засгийн газрыг “төрийн гүйцэтгэх дээд байгууллага” гэж тодорхойлсон. Ерөнхийлөгчийг шууд сонгодог бөгөөд 76 гишүүнтэй нэг танхимтай хууль тогтоох байгууллага (Улсын Их Хурал) нь олон нэр дэвшигч, шилжүүлэх боломжгүй санал хураалтын тогтолцооны дагуу сонгогддог бөгөөд УИХ-ын гишүүд нь пропорциональ бус олон мандаттай 29 (2-3 суудал) тойргоос сонгогддог бөгөөд тойрог бүрт ялалт байгуулсан нам нь сонгуулийн бүх суудлыг авсан болно.

2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Үндсэн хуульд тухайн үеийн засаглалын дагуу төрийн янз бүрийн салбаруудын эрх мэдлийн хүрээг тодорхой заагаагүй, хариуцагын олон тооны, ойлгомжгүй зүйлсийг агуулж байсан гэдэгтэй санал нэгдэж байсан нь ерөнхийлөгч, хууль тогтоох байгууллага, ерөнхий сайд хоорондын хурцадмал байдлыг улам нэмэгдүүлсэн юм. Улмаар Монгол Улс 1992-2020 онд 14 Ерөнхий сайдтай, Засгийн газар нь байнга солигдож, бодлого боловсруулалт, хэрэгжилт нь уялдаа муутай байснаас ихээхэн хохирол амссан. 2019 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны дараа⁵ төрийн янз бүрийн салбар хоорондын тэнцвэрт байдал Ерөнхийлөгч болон хууль тогтоох эрх мэдлээс Ерөнхий сайд руу шилжсэн. Өөрчлөлтүүдийн хувьд өмнө нь хоёр удаа дөрвөн жилийн бүрэн эрхийн хугацаатай байдаг байсан бол нэг удаа зургаан жилийн хугацаатай байхаар хязгаарласан нь Ерөнхийлөгчийн байр суурийг сулруулсан. Үүний улмаас Ерөнхий сайдын статус дээшилсэн. Ерөнхий сайд УИХ-ын гишүүдтэй зөвшилцөхгүйгээр Засгийн газрын гишүүдийг томилох/огцруулах боломжтой болсон. 2022 оны 8 дугаар сард Үндсэн хуулийн цэц УИХ-ын гишүүн байж болох Засгийн газрын гишүүдийн тоог дөрөв хүртэл хязгаарласан заалтыг хүчингүй болгосон.

³ 2020 оны сонгуулиар сонгогч, нэр дэвшигчдэд тавигдах шаардлага, сонгуультай холбоотой өргөдөл гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэхэд холбоотой байсан. АИХЭА-ны Үнэлгээний багийн ажлын тайлан, 2020 оны 4 дүгээр сар, 5 х.. 2021 оны сонгуульд эдгээр нь “Парламентад суудалгүй намууд болон бие даан нэр дэвшигчдийг нэр дэвшүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй гэдэг үндэслэлээр сонгох эрхийг хязгаарлах, маргааныг сунжруулах, хоёр шатны сонгуулийн сурталчилгааг хориглох, сонгуулийн сурталчилгааны санхүүжилтэд тавих хяналт хангалтгүй” зэрэг асуудлуудыг тусгасан. АИХЭА-ны Сонгуулийн тусгай үнэлгээний багийн тайлан, 2021 оны 10 дугаар сар, 1-р хуудас

⁴ АИХЭА-ны Сонгуулийн үнэлгээний хязгаарлагдмал багийн ажлын тайлан, 2017 оны 10 дугаар сар, 1-р хуудас.

⁵ 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр УИХ-аас 2019 оны 3 дугаар сард баталсан арга хэмжээг хүчингүй болгосноор Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд /гүйцэтгэх засаглал давамгайлдаг/ шүүгч, Авлигатай тэмцэх газрын дарга, Улсын ерөнхий прокурорыг шинээр томилох бүрэн эрхийг олгосон.

Хавсралт 1 – 1 дүгээр заалтын хүрээнд хийсэн улс төрийн нөхцөл байдлын үнэлгээ

Эдгээр өөрчлөлтийн үр дагавар, нөлөөллийг баттай дүгнэхэд эрт байгаа хэдий ч хариуцлага, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцвэрийг илүү тодорхой, үр дүнтэй болгох хэтийн төлөвийг харуулж байна.

Сонгогдсон албан тушаалтныг үр дүнтэй удирдах

Үндсэн хуульд сонгогдсон албан тушаалтнуудыг үр дүнтэй удирдах үндсийг тогтоосон. Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1-д “Монголын ард түмэн [төрийн эрх мэдлийг] төрийн үйл хэрэгт шууд оролцох, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж заасан байдаг. Тусгаар тогтносноос хойш сонгогдсон албан тушаалтнуудын эрх мэдэлтэй холбоотой тогтолцооны асуудал гараагүй.

Үндсэн хуульд Ерөнхийлөгч эсхүл УИХ онц байдал зарлаж болох тодорхой бөгөөд нарийвчилсан журмыг тогтоож, хүчирхийллийн эрсдэлийг бууруулах хяналт, тэнцвэртэй байдлыг бий болгосон.⁶

Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлийн 2-т төр, шашин хоёрыг тусгаарлах тухай заасан бөгөөд тусгаар тогтносноос хойш энэ заалттай холбоотой ноцтой асуудал гараагүй.

Монгол Улсын зэвсэгт хүчин, аюулгүй байдлын алба иргэний хяналтад байдаг бөгөөд улс төрийн шийдвэр гаргахад хөндлөнгөөс оролцдоггүй.

Иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, оролцоо

Иргэний нийгмийн цар хүрээ, бие даасан байдал

Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжид иргэний нийгэм бие даан үйл ажиллагаа явуулах үндсийг заасан. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10-д “Нийгмийн болон өөрийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэж заасан байдаг. Одоо мөрдөгдөж буй 1997 онд батлагдсан Төрийн бус байгууллагын тухай хуулийг ерөнхийд нь иргэний нийгмийн санаачилгыг дэмжсэн хууль гэж үздэг. Хүний эрхийн хэм хэмжээнд хяналт тавих үүрэгтэй олон улсын байгууллагууд иргэний нийгмийн байгууллагууд өргөн хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг гэж үнэлсэн. 2022 оны зун төрийн байгууллагууд стратегийн ач холбогдолтой дэд бүтцийн төслүүдийн талаархи иргэний нийгмийн шүүмжлэлийг үндэсний аюулгүй байдалд заналхийлж буй явдал гэж үзэж байгаад санаа зовниж байгаагаа илэрхийлсэн.

2019 оны сүүлчээр иргэний нийгмийн байгууллагуудын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг иргэний нийгмийн байгууллагуудаас өргөн мэдүүлсний дараа УИХ-д хэлэлцүүлэхээс татсан. 2020 онд Монгол Улсад 24 мянга гаруй ТББ бүртгэлтэй байсан. Сүүлийн арван жилийн хугацаанд бүртгэлтэй ТББ-ын тоо эрс нэмэгдсэн.⁷

Цензургүй ажилладаг бие даасан, олон ургальч үзэлтэй хэвлэл мэдээллийн хэрэгсэл

Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжид хараат бус, олон ургальч хэвлэл мэдээллийн хэрэгслийг цензургүй ажиллах суурийг тогтоосон. Үндсэн хуулийн 16-р зүйлийн 16-17-д иргэдийн бусад зүйлсээс гадна “Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтний”, “Мэдээлэл хайх, хүлээн авах” эрхийг баталгаажуулсан байдаг. Сүүлд заасан эрхийг хууль ёсоор тусгайлан тогтоосон төрийн нууцтай холбоотой шинж чанараас хамааран хамгаална.

⁶ 19 дүгээр зүйлийн 2, 25 дугаар зүйл, 1(17-18), 25, 2(1-2), 3 болон 35 дугаар зүйлийн 1(12) хэсэг.

⁷ Иргэний нийгмийн консорциум, Иргэний нийгмийн орон зайн өнөөгийн байдлыг судалж, түүний эрх зүйн таатай орчны хэрэгцээг тодорхойлох нь, Бүрэн тайлан, Улаанбаатар хот, 2021, 12 х.

Хавсралт 1 – 1 дүгээр заалтын хүрээнд хийсэн улс төрийн нөхцөл байдлын үнэлгээ

2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон Сонгуулийн тусгай үнэлгээний багийн тайланд 1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд төрийн хяналт шалгалтыг хориглож, 2017 онд доромжлох, гүтгэлгийг гэмт хэрэг гэж үзэхгүй гэснийг тэмдэглэсэн бөгөөд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг "телевизээс гадна улс төрийн мэдээллийн анхдагч эх сурвалж" болж байгааг, хэвлэл мэдээллийн орчинг "эрч хүчтэй" гэж тодорхойлсон. Гэсэн хэдий ч олон нийтийн телевиз улс төрийн хөндлөнгийн оролцоонд өртөмтгий байгаад, "худал мэдээлэл" болон гүтгэлэгт хэт өндөр хариуцлага хүлээлгэх заалтууд хэвээр байгаа эсхүл өөр хуулиудад тусгаж байгаад санаа зовниж байгаагаа илэрхийлсэн.⁸

"Сүүлийн жилүүдэд хэвлэл мэдээллийн орчин ерөнхийдөө сайжирч байна" гэдгийг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ олон хэвлэл мэдээллийн хэрэгсэл улс төрийн намд харьяалагдаж байгаад иргэний нийгмийн зүгээс санаа зовниж буйгаа илэрхийлсээр байна. Түүнчлэн 2020 онд хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хуульд худал мэдээлэл тараасан тохиолдолд хариуцлага хүлээлгэх тухай заалтууд байгаад санаа зовниж байгаагаа илэрхийлсэн байна.⁹

Иргэний болон улс төрийн оролцооны олон хэрэгсэл

Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжид иргэний болон улс төрийн оролцооны олон хэрэгслийн суурийг тогтоож өгсөн. Гуравдугаар зүйлд "Төрийн эрх мэдэл Монгол Улсын ард түмний мэдэлд байна. Үүнийг Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцох, мөн өөрсдийн сонгосон төрийн эрх барих төлөөллийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлнэ" гэж заасан. Энэ эрхийг 16 дугаар зүйлийн 9-д Монгол Улсын иргэн "төрийн үйл хэрэгт шууд буюу төлөөллийн байгууллагаар уламжлан оролцох эрхтэй" гэж тодотгосон. Өмнөх Улс орны стратегийн хугацаанд Дэлхийн банкны Дуу хоолой, хариуцлагын засаглалын үзүүлэлт эрс өссөн.

2020 оны УИХ-ын сонгуулийн Үнэлгээний багийн ажлын тайланд сонгуулийн тойргийн хэмжээтэй холбоотой зөрчилтэй асуудлууд үргэлжилсээр байгаа нь тус улсын хүн амын тал хувь нь Улаанбаатар хотод амьдарч байхад холбогдох тойргууд нь УИХ-ын суудлын гуравны нэгийг л бүрдүүлж байгаа гэсэн үг юм.¹⁰ 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнг үнэлэх Тусгай багийн тайланд дурдахдаа үндэс угсаа, эрүүл мэндийн байдал, ял шийтгэлийн улмаас нэр дэвших эрхийг хэт хязгаарлаж байгаад санаа зовниж буйгаа илэрхийлсэн.¹¹

Улс төрийн нам байгуулах эрх чөлөө, зохион байгуулалттай сөрөг хүчин байх

Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомж нь дээр дурдсанчлан, ялангуяа 16 дугаар зүйлийн 10-д заасан улс төрийн нам байгуулах эрх чөлөө, зохион байгуулалттай сөрөг хүчин байх үндсийг тогтоосон. Өмнөх Улс орны стратегийг баталснаас хойшхи хугацаанд эдгээр эрх, эрх чөлөөтэй холбогдуулан олон улсын холбогдох байгууллагуудаас ноцтой асуудал гаргаагүй.

Тусгаар тогтнолоо олж авснаас хойш АН, МАН гэсэн үндсэн хоёр нам төрийн эрх мэдлийн үндсэн салбаруудын хяналтыг ээлжлэн авч ирсэн. АН 1980-аад оны сүүлчээр болсон ардчилсан хөдөлгөөнөөс үүссэн бол МАН нь коммунист дэглэмийн үед төрийн эрх барьж байсан МАХН-ын үндсэн дээр байгуулагдсан. Гуравдагч намууд үе үе гарч ирж, заримдаа эрх баригч эвсэлд нэгдэж байсан. 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд "Зөв хүн" эвслээс нэр дэвшиж, фракцын зөрчилдөөнтэй байсан АН-ыг ялж, гуравдугаар байрт орсон.

⁸ АИХЭА-ны Сонгуулийн тусгай үнэлгээний багийн тайлан, 2021 оны 10 дугаар сар, 15-16-р хуудас

⁹ Хил хязгааргүй сурвалжлагчдын цахим хуудас, Монгол хуудас, 2022 оны 3 дугаар сар; 19 дүгээр зүйл/Транспэрэнси Интернэшнл, 2020 оны 4 дүгээр сарын 29. Прокурор.

¹⁰ АИХЭА-ны Үнэлгээний багийн тайлан, 2020 оны 4- дүгээр сар, 5-6-р хуудас. Түүнчлэн тайланд санал өгөх эрх нь (сэтгэцийн эрүүл мэнд, хорих ялтай холбоотой) болон нэр дэвших эрхийг (авлигын хэргээр мөрдөн шалгадаг байгаагаар холбогдуулан эрхийг нь хассан) хэт их хязгаарлалттай байгааг дурдсан. АИХЭА-ны тайлан, хуудас 7-8.

¹¹ АИХЭА-ны Сонгуулийн үнэлгээний тусгай багийн ажлын тайлан, 2021 оны 10- дугаар сар, 10-11-р хуудас. Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2-т Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь "Монгол Улсын уугуул иргэн, тавин нас хүрсэн, Монгол Улсад таваас доошгүй жил байнга оршин суусан иргэн байна" гэж зөвхөн байдаг.

Хавсралт 1 – 1 дүгээр заалтын хүрээнд хийсэн улс төрийн нөхцөл байдлын үнэлгээ

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд улс төрийн намуудын зорилго, сонгуульд оролцох үндсэн шаардлага, дотоод зохион байгуулалт, санхүүжилтийн зарчмуудыг тодорхойлсон 19 дүгээр зүйлийн 1-3 дахь нэмэлт заалт орсон.

Хууль дээдлэх ёс, шударга ёсны хүртээмж

Хуулийн засаглал

Үндсэн хуульд хууль дээдлэх үндсийг тогтоосон. Түүний оршил хэсэгт "хууль дээдлэх нь"-ийг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим гэж тунхагласан байдаг. 47 дугаар зүйлийн 1-3 дахь хэсэгт шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд шүүхийг дээдлэхийг тогтоосон. Түүнчлэн 10 дугаар зүйлийн 3-т Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн ормогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэж заасан.

Олон улсын холбогдох байгууллагууд өмнөх Улс орны стратегийн хугацаанд ахиц дэвшил гарсан зарим зүйлийг тэмдэглэсэн хэдий ч хууль дээдлэх ёс, засаглалын асуудал харьцангуй муу хэрэгжиж байгаад санаа зовниж байгаагаа илэрхийлсэн. Хууль дээдлэх чиглэлээр Дэлхийн банкнаас гаргасан Засгийн газрын үр ашиг, хууль дээдлэх Дэлхийн засаглалын үзүүлэлтүүд өмнөх Улс орны стратегийн үетэй харьцуулахад ахиц гарсаныг харуулж байгаа бол эхний үзүүлэлтийн хувьд Монгол Улсын үзүүлэлт тогтвортой байж, дараагийнх нь бага зэрэг өссөн байна.¹²

Шүүхийн хараат бус байдал

Үндсэн хуульд, ялангуяа 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн дараа шүүхийн хараат бус байх үндэс суурийг тодорхойлсон. 49 дүгээр зүйлийн 1-2 дахь хэсэгт Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, парламент, улс төрийн намыг хөндлөнгөөс оролцохыг үл зөвшөөрөх зэрэг шүүхийн хараат бус байх зарчмыг тогтоосон. 49 дүгээр зүйлийн 3-4 дэх хэсэгт шүүгчийн сонгон шалгаруулалт, тэдний ажиллах нөхцөлийг тогтоох замаар шүүгчийн хараат бус байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүргийг тодорхойлсон.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн шүүгчийг томилох эрхийг бууруулсан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг сонгох зарчмыг тодорхойлсон 49 дүгээр зүйлийн 5-д нэмэлт өөрчлөлт оруулсан нь энэхүү үйл явцад улс төрийн хөндлөнгийн оролцоог багасгахад чиглэсэн. Шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулахад улс төрийн хөндлөнгийн оролцоог багасгах зорилгоор Шүүхийн Сахилгын хорооны чиг үүргийг тодорхойлсон 49 дүгээр зүйлийн 6-д шинэ зүйлийг нэмж оруулсан.

УИХ-аас 2019 оны Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх зорилгоор 2021 оны 1 дүгээр сард Шүүхийн тухай хуулийг шинэчлэн баталсан. Эдгээр өөрчлөлт нь шүүхийн хараат бус байдлыг нэмэгдүүлэх боломжтой ч бодит амьдрал дээр хэрэгжих эсэхийг дүгнэхэд эрт байна.

Төр, иргэн хоёр хуулийн өмнө адил тэгш захирагдана

Төр болон иргэн хуулийн өмнө тэгш захирагдах үндсийг Үндсэн хуулиар тогтоосон. 14 дүгээр зүйлийн 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш байна” гэж заасан. 16 дугаар зүйлийн 14-д иргэдийн шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд оролцох эрхийг нарийвчлан тодорхойлсон.

¹² 2015-2020 онд Монгол Улсын Засгийн газрын үр дүнтэй байдлын үнэлгээ -0.57-аас -0.34, Хууль дээдлэх ёс -0.36-аас -0.26 болж, 34.93-аас 39.90, 43.60-аас 45.67 болж тус тус өссөн байна.

Хавсралт 1 – 1 дүгээр заалтын хүрээнд хийсэн улс төрийн нөхцөл байдлын үнэлгээ



European Bank
for Reconstruction and Development

Тавдугаар зүйлийн 2-3-т өмчлөх эрхийг хуулиар хамгаалсан. Гэсэн хэдий ч хөрөнгө оруулагчид захиргааны болон шүүхийн маргаан шийдвэрлэх ажиллагаанд төрийн албан хаагчид, улстөрчид хөндлөнгөөс оролцож байгаад санаа зовниж буйгаа илэрхийлсэн.¹³

Авлигаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй бодлого, байгууллага

Авлига нь нийгмийн амьдралын бүхий л салбарт ноцтой асуудал байсаар байгаа бөгөөд түүнийг шийдвэрлэх хүч чармайлт хангалтгүй байна.

¹⁴ Авлигын хэрэгт буруутгагдаж, нотлогдсон хэргүүд нийгмийн амьдралын дээд түвшинд түгээмэл байдаг. Олон шинжээчдийн үзэж байгаагаар авлига хээл хахуулийн хэрэгт буруутгагдаж, ялах үйл ажиллагаа нь ихэвчлэн улс төрийн шалтгаанаар олон нийтийн зүтгэлтнүүдийн эсрэг чиглэсэн байдаг. Үүний үр дагавар нь төр болон төрийн байгууллагуудад итгэх олон нийтийн итгэлийг бууруулж, бизнест зардал ноогдуулж, хөрөнгө оруулалтыг саатуулж байна.¹⁵

ЭЗХАХБ-аас 2019 оны 3 дугаар сард “Истанбулын авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний дөрөв дэх удаагийн хяналтын тайланд “Авлигын эсрэг хууль, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байна” гэж дүгнэсэн. Авлигатай тэмцэх газар бодлогын зохицуулалт, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, тодорхой хэмжээгээр эрчимжүүлсэн; гэсэн хэдий ч бүрэн эрхээ бүрэн хэрэгжүүлэхэд бие даасан байдал, нөөц бололцоо, төрийн эрх бүхий байгууллагаас шаардлагатай дэмжлэг дутмаг байна” гэсэн.¹⁶ Гэхдээ 2019 оны 3 дугаар сард Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд Авлигатай тэмцэх газрын даргыг томилох эрхийг олгосон нь эерэг алхам болсон гэж үзсэн.¹⁷

Транспэрэнси Интернэшнл байгууллагын авлигын индексийн үзүүлэлтээр Монгол Улсын оноо өмнөх стратегийн хугацаанд бараг өөрчлөгдөөгүй хэвээр байгаа бөгөөд 36-аас 35 болж бага зэрэг буурсан. Түүний зэрэглэл (180 орноос) илүү буурч, 103-аас 110 болсон.¹⁸

Засгийн газраас авлигатай тэмцэх үйл ажиллагаагаа эрчимжүүлэхээ амалсан. Шүүхийн хараат бус байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд нь эдгээр хүч чармайлтыг дэмжих болно. Засгийн газраас 2020-2021 онд цахим засаглалыг хөгжүүлэх томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар авлигатай тэмцэх хүч чармайлтад цахимжуулалтын гүйцэтгэх үүргийг онцолж байна. Эдгээр өөрчлөлт нь авлигатай тэмцэх үйл ажиллагааг сайжруулж болох ч бодит амьдрал дээр хэрэгжих эсэхийг дүгнэхэд эрт байна.

Иргэний болон улс төрийн эрх

Үг хэлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх, зорчих, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх, өмчлөх эрх чөлөө

Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжууд, тэр дундаа хүний эрхийн үндэсний механизмууд нь үг хэлэх, мэдээлэл авах, шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх, зорчих, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх, өмчлөх эрх чөлөөний үндэс суурийг тусгасан. Хүний эрх, эрх чөлөө гэсэн Хоёрдугаар бүлэгт (14-19-р зүйл) өргөн хүрээний эрх, эрх чөлөөг тусгасан. Өмнөх стратегийн хугацаанд хүний эрхийн хэм хэмжээг хангах тогтолцооны, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хэд хэдэн арга хэмжээ авсан.

¹³ 2021 оны Хөрөнгө оруулалтын орчны тухай мэдэгдлүүд: Монгол Улс, АНУ-ын Төрийн департаментын цахим хуудас.

¹⁴ Transparency International-ийн 2020 оны судалгаагаар судалгаанд оролцогчдын 69 хувь нь авлигыг “том асуудал” гэж үзсэн бол 56 хувь нь УИХ-ын гишүүдийг авлигач гэж үзсэн байна. Дэлхийн авлигын барометр - Ази 2020 он, 47-р хуудас.

¹⁵ 2021 оны 3-4-р сард явуулсан санал асуулгад оролцогчдын дөнгөж 23 хувь нь шүүхэд, 30 хувь нь улс төрийн намд, 33 хувь нь Авлигатай тэмцэх байгууллагад итгэдэг гэсэн. Санал асуулгын судалгааны IRI төв.

¹⁶ ЭЗХАХБ, Дөрөв дэх шатны хяналт шалгалт, Монгол Улс, 8 х.

¹⁷ Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг Улсын Их Хурал томиж, чөлөөлдөг.

¹⁸ 2021 оны 7 дугаар сард Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэт “Транспэрэнси Интернэшнл” байгууллагын авлигын төсөөллийн индекс дэх Монгол Улсын байр суурийг сайжруулах арга замыг судлах ажлын хэсгийг байгуулсан.

Хавсралт 1 – 1 дүгээр заалтын хүрээнд хийсэн улс төрийн нөхцөл байдлын үнэлгээ



European Bank
for Reconstruction and Development

Монгол Улс ардчилал болон хүний эрхийн стандартад хяналт тавих үүрэг бүхий олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилладаг. Сүүлийн улс орны стратеги батлагдсанаас хойшхи хугацаанд Монгол Улсад иргэний болон улс төрийн үндсэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үндэслэл бүхий анхаарал татах зүйл гараагүй. Монгол Улс НҮБ-ын хүний эрхийн үндсэн конвенцуудыг соёрхон баталж, 2004 оноос хойш бүх сэдэвчилсэн тусгай журамд нээлттэй урилга хүргүүлсээр ирсэн. Жил бүр ЕХ-той хүний эрхийн асуудлаар яриа хэлэлцээ хийдэг.

Хүний эрхийн хэм хэмжээнд хяналт тавих үүрэгтэй дотоодын гол байгууллага болох Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) нь хүний эрхийг дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын стандартыг тодорхойлсон 1993 оны НҮБ-ын Парисын зарчмуудыг бүрэн дагаж мөрдлөгө болгодог. 2020 оны 1 дүгээр сард шинэ хуулиар ХЭҮК-ын статусыг бэхжүүлж, комиссын гишүүдийн тоог нэмэгдүүлж, томилох журмыг илүү ил тод болгосон. УИХ-аас 2021 оны 4 дүгээр сард Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан. НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссар Мишель Бачелет “Энэ нь Монгол Улсын хувьд хүний эрхийн төлөө тууштай ажиллаж байгаагийн илэрхийлэл болсон томоохон амжилт” гэдгийг онцлон тэмдэглэсэн.¹⁹

Эмэгтэйчүүд, үндэстэн ястан болон бусад цөөнхийн улс төрийн оролцоо

Үндсэн хууль болон түүний холбогдох хууль тогтоомж нь ихэнхи тохиолдолд эмэгтэйчүүд, үндэстэн ястны болон бусад цөөнхийн улс төрийн оролцооны үндэс суурийг тодорхойлсон. 14 дүгээр зүйлийн 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэсэн. 16 дугаар зүйлийн 11-д “улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй” гэж заасан байдаг. Нийгмийн амьдралд тэгш оролцоог хангах чиг үүрэгтэй төрийн байгууллага болох Жендэрийн үндэсний хороог Ерөнхий сайд тэргүүлдэг.

Улс төрийн болон төрийн өндөр албан тушаалд эмэгтэйчүүдийн төлөөлөл ноцтой хэмжээнд бага хэвээр байна. Бүртгэлтэй нам, эвслүүдийн 20-иос доошгүй хувь нь эмэгтэй нэр дэвшигчид байх хуулийн квоттой хэдий ч УИХ-д эмэгтэйчүүдийн эзлэх суудлын хувь 17 орчим байгаа нь эзлэх хувь бага байгаа бөгөөд сүүлийн 10 жилийн хугацаанд бараг өөрчлөгдөөгүй байна.²⁰ АИХЭА-наас 2021 оны 6 дугаар сард болсон ерөнхийлөгчийн сонгуульд эмэгтэй нэр дэвшигчид оролцоогүй, сонгуулийн удирдлагын дээд шатны байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байгааг тэмдэглэсэн.²¹

2020 онд НҮБ-ын шинжээчид ялгаварлан гадуурхахын эсрэг иж бүрэн хууль тонтгоомжийг батлах тухай Монгол Улсад өмнө нь өгсөн зөвлөмжийг дахин сануулсан. Мөн “хөдөлмөр эрхлэлт, орон сууц, эрүүл мэнд, боловсрол зэрэг салбарт лесбиян, гей, бисексуал, трансжендер, интерсекс хүмүүсийг ялгаварлан гадуурхах явдал үргэлжилсээр байгаа, ижил хүйстэн хосуудыг хүлээн зөвшөөрөхгүй байгаад” санаа зовниж буйгаа илэрхийлсэн.²²

¹⁹ 2019 онд Хүний эрхийг хамгаалагчдын асуудлаарх Тусгай илтгэгчийн шүүмжилсэн илтгэлийн дараа уг хуулийг баталсан. 2021 оны 4-р сарын 30-ны өдрийн ОНСНР вэб сайтад хийсэн мэдэгдэл.

²⁰ Тус квотыг 2016 онд нэвтрүүлсэн. АИХЭБ-ны тайланд “кампанит ажлын өндөр зардал” нь эмэгтэйчүүдийн оролцоог саатуулж буй хүчин зүйл байж болзошгүй гэж тэмдэглэсэн. ODIHR Үнэлгээний багийн тайлан, 2020 оны 4-р сар, 2-р хуудас.

²¹ 2021 оны 10-р сар, 2-3, 4-5-р хуудас, АИХЭА-ны Сонгуулийн үнэлгээний тусгай багийн ажлын тайлан.

²² Хүний эрхийн зөвлөл. Монголын тухай эмхэтгэл. НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын тайлан, 2020 оны 3-р сар, 3-р хуудас.

Хавсралт 1 – 1 дүгээр заалтын хүрээнд хийсэн улс төрийн нөхцөл байдлын үнэлгээ

2021 оны 12 дугаар сард хийсэн айлчлалынхаа дараа НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч “Монгол Улсад эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийг батлахад ихээхэн ахиц дэвшил гарсныг сайшаасан” боловч илүү үр дүнтэй хэрэгжүүлэхийг уриалсан.²³

Монгол нь угсаатны хувьд харьцангуй нэг төрлийн улс. Казахууд хамгийн том цөөнх буюу 4 орчим хувийг бүрдүүлдэг бол хэд хэдэн монгол угсаатны цөөнх 6 орчим хувийг бүрдүүлдэг. Холбогдох байгууллагууд цөөнхийн хэлээр боловсрол эзэмших боломж, үндэсний цөөнхөд үзүүлэх эдийн засгийн хөгжлийн сөрөг нөлөөмийн талаар санаа тавьдаг.

Дарамт хавчлага, айлган сүрдүүлэх, эрүү шүүлтээс ангид байх

Үндсэн хуульд дарамт шахалт, айлган сүрдүүлэх, эрүү шүүлтээс ангид байх үндэс суурийг тогтоосон. 16 дугаар зүйлийн 13-т Монгол Улсын иргэн “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй” гэж заасан.

Монгол Улс 2020 онд ХЭҮК-ын дэргэд хоригдлуудыг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бус харьцах нөхцөлийг бууруулах зорилгоор цагдан хорих газруудтай танилцах Үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг байгуулсан. Гэсэн хэдий ч олон улсын холбогдох байгууллагууд, нэн ялангуяа Ковид-19 цар тахлын хүрээнд төр засгаас тогтоосон хязгаарлалтын улмаас хэрэгжилт хангалтгүй байгаад санаа зовниж байгаагаа илэрхийлсэн.²⁴

Хэдийгээр Монгол Улс цаазаар авах ялыг бүх талаараа халсан ч Үндсэн хуульд заасны дагуу энэ нь боломжтой хэвээр байна. Арван зургадугаар зүйлийн 1-д иргэн амьд явах эрхтэй, “Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно” гэж заасан байдаг.

²³ 2021 оны 12-р сарын 8-нд OHCHR вэб сайт дахь мэдэгдэл.

²⁴ НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос 2018 онд гаргасан зөвлөмжийн дагуу уг механизмыг бий болгосон. Хэрэгжихгүй байгаа зүйлийн талаар санаа зовниж буй талаар Монголын Эмнести Интернэшнл байгууллагын 2021 оны цахим хуудаснаас үзнэ үү.